



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН  
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ**

Монгол Улс, 17032, Улаанбаатар хот,  
Хан-Уул дүүрэг, Чингисийн өргөн чөлөө,  
Утас: 70101153, Факс: (976) 70101153  
E-mail: www.emd.gov.mn

**НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА Д.ОЮУНХОРОЛ ТАНАА**

2020.03.30 № 44  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**ЭМДҮЗ-ийн 2019 оны тайланг  
хүргүүлэх тухай**

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүдийн саналыг тусган, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны 2019 оны тайланг хүргүүлж байна.

Тайланд Үндэсний зөвлөлийн ажлын талаар болон Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооноос өгсөн чиглэлийн биелэлт, Эрүүл мэндийн даатгалын хуульд нэмэлт өөрчлөлт оруулах саналаа тусгасныг шийдвэрлэж өгөхийг танаас хүсье.

Хавсралт <sup>43</sup> хуудастай.

Хүндэтгэсэн,

ДАРГА



Д.САРАНГЭРЭЛ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ



# 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ  
2020 он

## АГУУЛГА

### Нэг. Эрүүл мэндийн даатгалын сангийн байдал

- 1.1 Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, төсвийн гүйцэтгэл
- 1.2 Эрүүл мэндийн даатгалын шимтгэл, түүний хувь, хэмжээ
- 1.3 Эрүүл мэндийн даатгалын хамралт
- 1.4 Эрүүл мэндийн даатгалын сангийн зарцуулалт, сангаас төлбөрийг нь хариуцах тусламж үйлчилгээ
- 1.5 Эрүүл мэндийн даатгалын цахим систем

### Хоёр. Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

- 2.1 Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол, шийдвэрийн хэрэгжилт
  - 2.1.1 Эрүүл мэндийн даатгалын санг удирдах, нөөцийг нэмэгдүүлэх
  - 2.1.2 Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний төрөл, чанар, хүртээмж
  - 2.1.3 Эрүүл мэндийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, орон тооны хангамж хүрэлцээ
- 2.2 УИХ-ын НББСШУ-ны байнгын хорооны шийдвэр, үүрэг, чиглэлийн биелэлт
- 2.3 Монгол Улсын Засгийн газрын шийдвэр, мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт

### Гурав. Үндэсний зөвлөлийн үйл ажиллагаа

- 3.1 Бүтэц, зохион байгуулалт
- 3.2 2019 оны үйл ажиллагаа

### Дөрөв. Дүгнэлт, санал

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт 1. Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэл
- Хүснэгт 2. Эрүүл мэндийн даатгалын 2019 оны шимтгэлийн хувь, хэмжээ
- Хүснэгт 3. Эрүүл мэндийн даатгалын хамралтын байдал
- Хүснэгт 4. Эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон тусламж үйлчилгээний зардал
- Хүснэгт 5. Даатгалын гэрээтэй эрүүл мэндийн байгууллагын тоо
- Хүснэгт 6. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэл
- Хүснэгт 7. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын эрүүл мэндийн даатгалын сангаас төлөх төлбөрийн хэмжээ
- Хүснэгт 8. Зайлшгүй шаардлагатай эмийн үнийн хөнгөлөлтийн зардал
- Хүснэгт 9. Элэг бүтэн Монгол” хөтөлбөрт зарцуулсан зардал

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

УИХ	Улсын Их Хурал
НББСШУБХ	Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо
ЗГ	Засгийн газар
ЗГҮАХ	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр
ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ХЗДХЯ	Хууль зүй дотоод хэргийн яам
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ЭМД	Эрүүл мэндийн даатгал
ЭМБ	Эрүүл мэндийн байгууллага
СЯ	Сангийн яам
АХБ	Азийн хөгжлийн банк

## ХАВСРАЛТ

1. Тайланд холбогдох диаграм, хүснэгтүүд
2. Байнгын хорооны шийдвэр, үүргийн биелэлт
3. Эрүүл мэндийн даатгалын хуульд орох зарим нэмэлт өөрчлөлтийн тухай хуулийн төсөл, танилцуулга

## НЭГ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН БАЙДАЛ

2019 онд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл нь төрөөс эрүүл мэндийн даатгалын талаар баримтлах бодлого, зорилтуудын хэрэгжилтийг хангуулах, даатгалын сангийн хөрөнгийг зарцуулах орлого, зарлага, санхүүгийн байдалд хяналт тавьж үнэлэлт дүгнэлт өгөх, эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллалаа.

Тайлант хугацаанд Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж болон УИХ-ын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооноос өгсөн чиглэлийг үйл ажиллагаандаа удирдлага болгов.

### 1.1 Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, төсвийн гүйцэтгэл

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай хуулиар Эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлэх нийт орлогын хэмжээг 407.6 тэрбум төгрөг, үүнээс ажил олгогч, даатгуулагч, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлого 323.8 тэрбум төгрөг, төр даатгалыг нь хариуцах иргэдийн шимтгэлийг 83.9 тэрбум төгрөг, бусад орлогыг 39.3 тэрбум төгрөгөөр, эрүүл мэндийн даатгалын төсвийн нийт зарлагыг 407.6 тэрбум төгрөг, үүнээс тусламж, үйлчилгээнд 402.3 тэрбум төгрөг, эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардлыг 5.4 тэрбум төгрөгөөр Улсын Их Хурлаас баталсан.

#### Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэл, 2017-2019 он

Хүснэгт.1.

Эрүүл мэндийн даатгалын сан		2017 он	2018 он		2019 он	
		Гүйцэтгэл	Төсөв	Гүйцэтгэл	Төсөв	Гүйцэтгэл
<b>А. ОРЛОГО</b>		366,423.4	376,011.9	422,340.2	407,667.3	469,419.8
1	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	317,713.6	336,684.6	374,745.1	368,334.6	426,881.0
2	Бусад орлого	48,709.8	39,327.3	47,595.1	39,332.7	42,538.8
<b>Б. ЗАРЛАГА</b>		294,851.00	341,330.60	311,725.9	407,667.3	350,956.4
1	Тусламж үйлчилгээний зардал	290,701.8	337,039.1	308,171.0	399,171.3	346,127.8
2	Үйл ажиллагааны зардал	4,110.9	4,017.9	3,379.1	5,422.4	4,569.1
3	ШШБА-ны урамшуулал	38.3	33.6	5.5	800.0	0.5
4	Илүү төлсөн шимтгэлийн буцаан олголт	-	240.0	170.3	273.6	259.0

2019 онд Эрүүл мэндийн даатгалын санд 469.4 тэрбум төгрөг бүрдүүлж, орлогын төлөвлөгөөг 115.2 хувиар биелүүллээ. Үүнээс 426.9 тэрбум төгрөгийн

шимтгэлийн орлого бүрдүүлж, энэ нь төлөвлөснөөс 58.5 тэрбум төгрөгөөр давж биеллээ.

Бусад орлого 39.3 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээс 42.5 тэрбум төгрөг орж, 3.2 тэрбум төгрөгөөр орлогын төлөвлөгөө давж биелсэн.

Мөн онд Эрүүл мэндийн даатгалын сангийн нийт зарцуулсан зардал 350.9 тэрбум төгрөг, үүнээс төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудад 236.8 тэрбум төгрөг, хувийн хэвшлийн эмнэлгээр үйлчлүүлэх зардалд 37.3 тэрбум төгрөг, рашаан сувиллаар үйлчлүүлэх зардалд 10.6 тэрбум төгрөг, өрхийн эрүүл мэндийн төвөөс үзүүлэх тусламж үйлчилгээний зардалд 8.9 тэрбум төгрөг, зайлшгүй шаардлагатай эмийн үнийн хөнгөлөлтийн зардалд 33.4 тэрбум төгрөг, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээний зардалд 3.9 тэрбум төгрөг, "Элэг бүтэн Монгол" хөтөлбөрийн зардалд 15.1 тэрбум төгрөг, үйл ажиллагааны зардалд 4,6 тэрбум төгрөг тус тус зарцууллаа.

Эрүүл мэндийн даатгалын төсөв, түүний гүйцэтгэлийн байдлыг өмнөх 2 жилийн байдалтай харьцуулахад сүүлийн жилүүдэд ЭМД-ын даатгуулагчаас төлөх шимтгэлийн хувь хэмжээг нэмэгдүүлээгүй ч орлогын төлөвлөгөөг биелүүлэх талаар авч буй арга хэмжээний үр дүнд сангийн орлого жил дараалан өсч, зөвхөн 2019 онд 2017 оныхоос 103.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн, тусламж, үйлчилгээний зардал 2019 онд 2017 оныхоос 55.4 тэрбум төгрөгөөр өссөн нь даатгуулагч иргэдэд үзүүлэх тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн байна.

## **1.2 Эрүүл мэндийн даатгалын шимтгэл, түүний хувь, хэмжээ**

Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд зааснаар Монгол Улсын бүх иргэн эрүүл мэндийн даатгалд албан журмаар даатгуулах үүрэгтэй бөгөөд даатгуулагчийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хэмжээг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар жил бүр тогтоож байна.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд аж ахуйн нэгж, байгууллага, ажилтны сард төлөх шимтгэлийн хэмжээг түүний хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 4-өөс доошгүй хувиар, их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн суралцагч, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчин, ажил хөдөлмөр эрхлээгүй иргэн болон 0-18 насны хүүхдийн эрүүл мэндийн даатгалын сарын шимтгэлийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1-ээс доошгүй хувиар, бусад даатгуулагчийн эрүүл мэндийн даатгалын сарын шимтгэлийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 2-оос доошгүй хувиар тогтоохоор заасан. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар энэхүү тогтоосон хэмжээгээр даатгуулагч иргэдээс орлого бүрдүүлэх ажлыг зохион байгуулав.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл шимтгэлийн хувь хэмжээг урьдах онуудаас нэмэгдүүлэхгүй байх бодлого баримтлав. Энэ талаарх саналаа



Монгол улсын Засгийн газарт хүргүүлж, Засгийн газрын 2018 оны 401 дүгээр тогтоолоор “Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн 2019 оны хэмжээ”-г зөвшөөрч, шинэчлэн тогтоосон юм.

Шимтгэл төлөлтийн энэ байдал нь даатгуулагч иргэдэд дарамт үзүүлэхээргүй байгаа бөгөөд 2020 онд зөвхөн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний өөрчлөлтөөс өөрөөр энэ байдлыг хэвээр үргэлжлүүлэх бодлогыг Үндэсний зөвлөл баримталж байна.

### Эрүүл мэндийн даатгалын 2019 оны шимтгэлийн хувь, хэмжээ

Хүснэгт.2.

№	Даатгуулагчдын төрөл	Шимтгэлийн 2019 оны хэмжээ	Төлөх хугацаа
1	Аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан	Хөдөлмөр хөлс түүнтэй адилтгах орлогын 4-өөс доошгүй хувиар, үүнээс ажил олгогч 2 хувь, ажилтан 2 хувь	Сар бүр
2	0-18 насны хүүхэд	3200 төгрөг /Хөдөлмөр хөлсний доод хэмжээний 1%/	Хагас, эсхүл бүтэн жилээр
3	Их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн суралцагч		
4	Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчин, тодорхой хөдөлмөр эрхлээгүй иргэн	3200 төгрөг /Хөдөлмөр хөлсний доод хэмжээний 1%/	Хагас, эсхүл бүтэн жилээр
5	Төрөөс шимтгэлийг нь хариуцан төлөх иргэн	6400 төгрөг /Хөдөлмөр хөлсний доод хэмжээний 2%/	Сар бүр

### 1.3. Эрүүл мэндийн даатгалын хамралт

Тайлант онд 2920.8 мянган даатгуулагч эрүүл мэндийн даатгалд хамрагдаж, хамралтын түвшин 90.2 хувьтай байна.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн холбогдох заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор дараах байгууллагуудтай гэрээ хийж, биелэлтэд хяналт тавьж байна. Үүнд:

-Нийгмийн даатгалын байгууллагатай хамрах хүрээг өргөтгөх, сангийн орлогын бүрдүүлэлтийг сайжруулах чиглэлээр;

-Улсын бүртгэлийн байгууллагатай мэдээлэл солилцох чиглэлээр;

-Нийгмийн халамж, үйлчилгээний байгууллагатай эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төрөөс хариуцах иргэдийн талаар;

-Хил хамгаалах ерөнхий газар болон Зэвсэгт хүчний жанжин штабтай цэргийн жинхэнэ алба хаагчдыг эрүүл мэндийн даатгалд хамруулах талаар;

-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газартай ял эдэлж байгаа ялтныг эрүүл мэндийн даатгалд хамруулах чиглэлээр тус тус хамтран ажиллаж байна.

2019 онд ЭМД-д хамрагдсан хүний тоо 2018 оноос 96.1 мянган даатгуулагчаар буюу 1.3 хувиар нэмэгдлээ.

Аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, ажилгүй иргэн, их, дээд сургууль болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцагч, малчин, хоригдлын эрүүл мэндийн даатгалын хамралт буурч, гадаадын харьяалалтай иргэн, төрөөс шимтгэлийг хариуцах иргэдийн хамралт нэмэгдсэн

байна. Малчид, оюутнуудыг эрүүл мэндийн даатгалд хамруулахад ЭМД-ын шат, шатны байгууллагуудаас ажиллах ажиллагааг сайжруулах шаардлагатай гэж үзэж байна.

### Эрүүл мэндийн даатгалын хамралтын байдал, 2018-2019 он

Хүснэгт.3.

№	Хамралтын төрөл	Даатгуулагчийн тоо /мянган хүн/	
		2018 он	2019 он
1	Аж ахуйн нэгж байгууллагын ажилтан	745.2	735.0
2	Аж ахуйн нэгжийн эзэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, ажилгүй иргэн	175.0	119.4
3	Их дээд, сургууль болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцагч	47.2	19.7
4	Малчин	93.0	67.6
5	Гадаадын харьяалалтай иргэн	0.1	0.2
6	ЭМД-ыг төрөөс хариуцдаг иргэн	1,763.9	1,978.7
Нийт		2,824.7	2,920.8
Хувь		88.9	90.2

#### 1.4 Эрүүл мэндийн даатгалын сангийн зарцуулалт, сангаас төлбөрийг нь хариуцах тусламж үйлчилгээ

Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох тусламж үйлчилгээний зардалд 2019 онд 399.2 тэрбум төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 346.1 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Үүнд: төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудад 236.8 тэрбум төгрөг, хувийн хэвшлийн эмнэлгээр үйлчлүүлэх зардалд 37.3 тэрбум төгрөг, рашаан сувиллаар үйлчлүүлэх зардалд 10.5 тэрбум төгрөг, өрхийн эрүүл мэндийн төвөөс үзүүлэх тусламж үйлчилгээний зардалд 8.9 тэрбум төгрөг, зайлшгүй шаардлагатай эмийн үнийн хөнгөлөлтийн зардалд 33.4 тэрбум төгрөг, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээний зардалд 3.9 тэрбум төгрөг, “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн зардалд 15.1 тэрбум төгрөг тус тус зарцууллаа.

Эрүүл мэндийн даатгалын сангаас төлбөрийг нь хариуцаж байгаа тусламж үйлчилгээний зардлууд жил бүр нэмэгдэж байгаа нь даатгуулагч иргэдийн эрсдэлээс хуваалцаж байгаа сайн талтай ч, жилд төсөвлөсөн зардлууд бүрэн зарцуулагдахгүй байгаа нь эрүүл мэндийн байгууллагууд чанартай тусламж үйлчилгээг гэрээнд заасан нөхцөл, шаардлагыг хангаж хангалттай хэмжээнд үзүүлж, зардлаа нэхэмжилж авч чадахгүй байгаатай холбоотой байна. Мөн сангийн зардлын төлөвлөлт, зарцуулалт зохих шаардлагын түвшинд хийгдэж, төлбөр тооцооны үйл ажиллагааны байдлаас шалтгаалж байгаад зохих дүгнэлт хийж ажиллаж байна.

**Эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон  
тусламж үйлчилгээний зардал, 2017-2019 он, тэрбум төгрөгөөр**

Хүснэгт.4.

Тусламж үйлчилгээний төрөл	2017 он	2018 он		2019 он	
	Гүйцэтгэл	Төсөв	Гүйцэтгэл	Төсөв	Гүйцэтгэл
1 Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагууд	198.1	214.5	213.2	244.5	236.8
2 Хувийн хэвшлийн эмнэлгээр үйлчлүүлэх	34.1	42.0	35.0	48.8	37.3
3 Рашаан, сувиллаар үйлчлүүлэх даатгуулагчийн зардал	10.3	12.6	10.1	13.0	10.5
4 Өрхийн эрүүл мэндийн төвөөс үзүүлэх зарим сэргээн засах үйлчилгээ, өдрийн эмчилгээ, асаргаа, сувилгаа, оношлогоо, шинжилгээ;	-	5.2	1.7	15.8	8.9
5 Зайлшгүй шаардлагатай эмийн үнийн хөнгөлөлтийн зардал	26.8	30.8	25.9	33.9	33.4
6 Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээний зардал	2.9	5.1	2.2	10.1	3.9
7 Идэвхитэй хөдөлгөөн, спортоор хичээллэх үйлчилгээний зардал	-	-	-	2.0	0.0
8 "Элэг бүтэн Монгол" хөтөлбөрт зарцуулсан зардал		26.7	19.8	31.7	15.0
<b>Нийт</b>	<b>290.7</b>	<b>337.0</b>	<b>308.2</b>	<b>399.2</b>	<b>346.1</b>

2019 онд эрүүл мэндийн 2122 байгууллагатай ЭМД-ын байгууллага гэрээтэй ажиллаж, эрүүл мэндийн байгууллагаас эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг хариуцах хэвтүүлэн эмчлэх, амбулаторийн үзлэг, оношлогоо, шинжилгээ, өдрийн эмчилгээ, хорт хавдрын болон хөнгөвчлөх тусламж үйлчилгээ, уламжлалт, сэргээн засах болон сувиллын тусламж үйлчилгээ, өндөр өртөгтэй тусламж үйлчилгээ, эмийн үнийн хөнгөлөлт, эмнэлгийн хэрэгсэл, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх тусламж үйлчилгээ, хорт хавдрын химийн болон туяаны өдрийн эмчилгээ, магадлан итгэмжлэгдсэн спортын клубт идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх үйлчилгээг үзүүлж байна.

**Даатгалын гэрээтэй эрүүл мэндийн байгууллагын тоо, 2017-2019 он**

Хүснэгт.5.

№	ЭМБ-ын төрөл, тусламж, үйлчилгээний ангилал	2017 он	2018 он	2019 он
1	Улсын эмнэлэг	97	97	102
2	Хувийн эмнэлэг	185	169	179
3	Рашаан сувилал	48	49	58
4	Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв		292	424
5	Эмийн сан	861	835	1009
6	Элэгний В,С вирусийн идэвхжил тодорхойлох лаборатори	21	28	28
7	Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг багцын шинжилгээ	77	156	150
8	Гемодиализийн тусламж, үйлчилгээ	7	6	11
9	"Эрүүл шүд-Эрүүл хүүхэд" хөтөлбөр			161
	<b>Нийт</b>	<b>1297</b>	<b>1632</b>	<b>2122</b>

2019 онд тусламж үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн байгууллагын тоо нь өмнөх онтой харьцуулахад 490 байгууллагаар нэмэгдсэн нь даатгуулагч иргэдийн үйлчлүүлэх эрүүл мэндийн байгууллагын хүртээмж нэмэгдсэн, тусламж үйлчилгээ авахад хүндрэл, чирэгдэл багассан байна. 2018 оноос 2019 онд үйлчилгээ үзүүлэгч өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв 132-оор, эмийн сан 174-өөр тус тус өссөн байна.

### 1.5 Эрүүл мэндийн даатгалын цахим систем

Эрүүл мэндийн даатгалын байгууллагын төлбөр, тооцоо, даатгуулагчид болон ажил үйлчилгээ худалдан авах байгууллагуудтай харилцах, даатгалын санд хяналт тавих ажиллагаа үндсэндээ цахимжих хэлбэрт шилжиж байна. Энэ талаар Үндэсний зөвлөл, ЭМДЕГ-аас сүүлийн 2 жилд тодорхой зорилт тавьж, түүнийгээ хэрэгжүүлж байна. Монгол Улсын Засгийн газраас 2017 онд баталсан “Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого”, 2018 онд баталсан “Гурван талт хөгжлийн бодлого”, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичигт тусгасан зорилтын хүрээнд эрүүл мэндийн даатгалын салбарт цахим системийг хөгжүүлэх, тоон технологийг нэвтрүүлэх замаар Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээг даатгуулагч төвтэй хэлбэрт шилжүүлэн хүнд суртал, зардал чирэгдлийг бууруулах, иргэдийн цахим оролцоог хангах, даатгалтай холбоотой мэдээлэл, өгөгдлийг даатгуулагчдад нээлттэй байршуулах, цахим эргэх холбоо, хяналтыг нэвтрүүлэх талаар тавьсан зорилттой нягт уялдаж, үр дүнд хүргэх боломжтой байна. Энэ талаар УИХ-ын НББСШУ-ны байнгын хороо онцгой анхаарч, чиглэл өгсөн байна.

“Эрүүл мэндийн даатгалын цахим систем”-ийг 2018 оноос “Цахим жор”, “Элэг бүтэн Монгол” хөтөлбөр, “Урьдчилан сэргийлэх үзлэг”, “Өрх, сумын эрүүл мэндийн төв”-ийн дэд програмуудыг үе шаттайгаар хэрэгжиж байна.

“Эрүүл мэндийн даатгалын цахим систем”-ийг өргөтгөн “Эрүүл шүд-Эрүүл хүүхэд”, эрүүл мэндийн даатгалын сангийн зардлын бүртгэлийн програм “HICS” систем, “Е баримт хэвлэх систем”, “Өндөр өртөгтэй тусламж, үйлчилгээний дэд систем”, “Ухаалаг утасны апп”-ыг тус тус шинээр нэвтрүүлж, “Спортын клубын дэд систем”-ийн бэлтгэл ажил хангагдлаа.

Ингэснээр эрүүл мэндийн даатгалын гэрээ бүхий эмийн сангууд болон өрх, сумын эрүүл мэндийн төвүүдэд эрүүл мэндийн даатгалын цахим жорын систем ашиглан өрхийн эмчийн жор бичилт, эмийн сангийн эм олголтыг эмийн нэр төрөл, өрхийн эмч, эмийн сан, даатгуулагч тус бүрээр цаг, минутаар нь бүртгэж, хяналт тавих нөхцөлийг бүрдүүлэв. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны мөрийн хөтөлбөрийн 3.1.14. дэх хэсэгт тусгагдсан “Эрүүл мэндийн салбарын цахим системийг хөгжүүлж, өвчний түүхийг цахимжуулан, эмнэлгүүдийн мэдээллийн технологийг боловсронгуй болгох, чирэгдлийг эрс бууруулж, цогц арга хэмжээг авах” гэсэн зорилтын хүрээнд Эрүүл мэндийн даатгалын байгууллагаас “Эрүүл мэндийн даатгалын цахим систем”-ийг үе шаттайгаар амжилттай нэвтрүүлж байна. Уг цахим системээр цахим жор, “Элэг бүтэн Монгол” хөтөлбөр, урьдчилан

сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх 4 төрлийн тусламж, үйлчилгээ болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын үзүүлсэн тусламж, үйлчилгээний чанар, зардлын төлбөрийн хяналтыг цахимаар хийж байна.

Эдгээр зорилтыг хангасны үр дүнд Эрүүл мэндийн даатгалын салбарын хэмжээнд 2019 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс ЭМД-ын төлбөрийн баримтын системийг нэвтрүүлж байгаатай холбогдуулан гэрээт хувийн хэвшлийн эмнэлэг, сувилал, сэргээн засах төвүүдтэй “Багц баримт олгох эрхийн харилцааг зохицуулах, хамтран ажиллах гэрээ” байгуулж, эрүүл мэндийн байгууллагаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авч байгаа иргэд-даатгуулагчийн мэдээллийг шуурхай авч санхүүжилтийг шийдвэрлэх боломжтой боллоо.

## ХОЁР. ХУУЛЬ, ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд эрүүл мэндийн даатгалын талаарх дүрэм журамд өөрчлөлт оруулан, шинэчлэх арга хэмжээг үргэлжлүүлэн авч байна.

Тайлант хугацаанд Үндэсний зөвлөлөөс баталсан дүрэм, журам, жагсаалтыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн холбогдох нэмэлт өөрчлөлт, шинэчлэн боловсруулж, нийтээр дагаж мөрдөх эмийн үнийн жагсаалт, магадлан итгэмжлэгдсэн спортын клубт идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх үйлчилгээ үзүүлэх журам, эрүүл мэндийн даатгалын сангаас зардлыг хариуцах тусламж үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журмын нэмэлт өөрчлөлт, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх зарим тусламж, үйлчилгээнд эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг хариуцах журам, оношилгоо, шинжилгээний жагсаалт, төлбөрийн дээд хязгаар, үнэ тариф, өртгийн жин, өдрийн эмчилгээний оношийн хамааралтай бүлгийн жагсаалтыг шинэчлэн баталж, ХЗДХЯ-нд бүртгүүллээ.

### **2.1 Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол, шийдвэрийн хэрэгжилт**

Монгол улсын Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, УИХ-ын НББСШУ-ны байнгын хорооны тогтоол, Засгийн газрын мөрийн хөтөлбөр болон тогтоолд тусгагдсан эрүүл мэндийн даатгалын бодлогыг хэрэгжүүлэх, иргэн бүрт эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэх, даатгалын тогтолцоог боловсронгуй болгох талаар Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөс холбогдох тогтоол, шийдвэрүүдийг гарган мөрдүүлж байна.

#### **2.1.1 Эрүүл мэндийн даатгалын санг удирдан чиглүүлэх, нөөцийг нэмэгдүүлэх**

а/ Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн 2019 оны нарийвчилсан хуваарь баталж, биелэлтийг хангуулж байна. Үүний үр дүнд эрүүл мэндийн даатгалын сангийн 2019 оны орлого 469.4 тэрбум төгрөг болж, төлөвлөгөө 115.2 хувиар биелэгдлээ. Үүнээс шимтгэлийн орлого 58.5 тэрбум төгрөгөөр, бусад орлого 3.2 тэрбум төгрөгөөр тус тус давж биелсэн байна.

б/ “ЭМД-ын сангийн чөлөөт үлдэгдлийг зарцуулах, банкинд хадгалуулах, ЗГ-ын бонд, Монгол банкны үнэт цаас худалдан авах” журмыг шинэчлэн, эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгийг банкинд хадгалуулах бонд, үнэт цаас худалдан авахдаа эрсдэлгүй, эдийн засгийн үр ашигтай байх зарчмыг баримталж байна. Журманд мөнгөн хадгаламж байршуулах, банкинд тавигдах шаардлага, бүртгэл хийх, тайлагнах зарчим тодорхой тусгагдсан. 2019 онд эрүүл мэндийн даатгалын сангийн чөлөөт мөнгөн хөрөнгийг арилжааны банкуудад байршуулсан бөгөөд хадгаламжийн жилийн дундаж хүү 12.4 хувь болсон байна. 2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар эрүүл мэндийн даатгалын сангийн харилцах дансанд 324.5 тэрбум төгрөг, хадгаламж

хэлбэрээр ЭМД-ын сангийн чөлөөт үлдэгдэл 233.0 тэрбум төгрөг 7 банкинд байршиж байна.

Тайлант оны эцэст эрүүл мэндийн даатгалын сан 693.6 тэрбум төгрөг /Капитал банкны 136.1 тэрбум төгрөг ороод/ мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байгаа нь өмнөх оны мөн үеэс 118.6 тэрбум төгрөг буюу 120.6 хувиар өссөн дүнтэй байна.

в/ Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас Капитал банкны эрүүл мэндийн даатгалын хөрөнгийн өрийн асуудалд ихээхэн анхаарал тавьж ажиллаж, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн 2012 оноос Капитал банкинд Эрүүл мэндийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийг харилцах болон хадгаламжийн хэлбэрээр байршуулж эхэлснээр энэ өр үүссэн. Өрийн асуудлыг шийдвэрлэх талаар Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл 2019 оны 08 дугаар сард тогтоол гаргаж, Эрүүл мэндийн даатгалын сангийн Капитал банкинд байршиж байсан мөнгөн хөрөнгийн оронд тус банкны эд хөрөнгө, үл хөдлөх хөрөнгийг авах асуудлыг судлан, танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллуулж байна.

Ажлын хэсэг нь Монголбанкны Ерөнхийлөгчийн А-302 дугаар тушаалаар батлагдсан Банкныг албадан татан буулгах арга хэмжээг хэрэгжүүлэх журмын 6.1 дэх заалт, Банкны тухай хуулийн 73 дугаар зүйлд заасны дагуу банкны эрх хүлээн авагчид холбогдох нэхэмжлэлийг гаргаж өгсөн.

Капитал банкны эрх хүлээн авагчийн зүгээс 2019 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр төлбөрийг 136.1 тэрбум төгрөгөө баталгаажуулж, "Төлбөр барагдуулах дараалал"-ыг тогтоосон тухай мэдэгдсэн. Энэхүү мэдэгдэл нь бодит байдлыг судлаагүй, эрүүл мэндийн даатгалын санг гурван сая даатгуулагч иргэдийн банкинд хадгаламж хэлбэрээр байршиж байгаа мөнгө болохыг үл хэрэгссэн, хууль бус шийдвэр гарсан гэж үзэж, Захиргааны хэргийн шүүхэд хандаад байна. Мөн иргэний хэрэг гэж үзэх үндэс байгаа тул Иргэний хэргийн шүүхэд өгөхөөр бэлтгэж байна. Капитал банкныг татан буулгахдаа харилцагчийн эрхийг хамгаалах Монголбанкны хуулийн тодорхой заалтыг үл хүндэтгэсэн, эрүүл мэндийн даатгалын байгууллагаас төлбөр хийлгүүлэхээр удаа дараагийн тавьсан шаардлага, нэхэмжлэлийг хангаагүй, эрүүл мэндийн даатгалын хадгаламжийг эхний ээлжинд гаргуулж өгнө гэх зэргээр хойш тавьж, Капитал банкныг гэнэт татан буулгаснаас даатгалын сан хохирох ёсгүй юм. Ийм учраас Монголбанк уг асуудлын хариуцлагыг хүлээх ёстой гэж үзэж байна. Олон мянган иргэд, даатгуулагч, байгууллага Капитал банкныг татан буулгахад хариуцлагагүй хандсанаас хохирч болзошгүй байдлыг УИХ анхааралдаа авч, энэ талаар тодорхой чиглэл, шийдэл гаргаж өгөх байх гэдэгт найдаж байна.

### **2.1.2 Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний төрөл, чанар, хүртээмж**

*а/ Өрх сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх тусламж, үйлчилгээ*

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9-д өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх зарим сэргээн засах үйлчилгээ, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ, өдрийн эмчилгээ, оношилгоо, шинжилгээнд эрүүл мэндийн

даатгалын сангаас зардлын төлбөр олгохоор заасныг хэрэгжүүлэхээр Үндэсний зөвлөлөөс “Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх зарим тусламж, үйлчилгээнд эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг хариуцах журам”-ыг баталсан. Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс шинээр 4 төрлийн тусламж үйлчилгээг үзүүлэх болсноор тусламж, үйлчилгээний хүртээмж нэмэгдэж, төрийн өмчийн эмнэлгийн байгууллагуудын ачааллыг бууруулах боломж бүрдэж, иргэдэд үйлчилгээг ойртуулсан алхам болсон.

2019 онд дээрх журам, даатгалын сангаас төлөх төлбөрийн хэмжээг шинэчлэн боловсруулж, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх сэргээн засах тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээг 20.0 мянган төгрөг байсныг 45.0 мянган төгрөг болгон нэмэгдүүлж 2.2 дахин, өдрийн эмчилгээнд 30.0 мянган төгрөг байсныг 70.0 мянган төгрөг болгон 2.3 дахин, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээний төлбөрийг 25.0 мянган төгрөг байсныг 50.0-70.0 мянган төгрөг болгож 2-2.8 дахин нэмэгдүүлсэн юм. Үүнтэй уялдуулан эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх оношилгоо, шинжилгээний жагсаалт, төлбөрийн дээд хязгаар болон өдрийн эмчилгээний оношийн хамааралтай бүлгийн жагсаалт, өртгийн жинг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл шинээр баталсан юм.

**Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэл, 2018-2019 он**

**Хүснэгт.6.**

Тусламж, үйлчилгээний төрөл	2018 он		2019 он	
	Хүний тоо	Мөнгөн дүн /сая.төг/	Хүний тоо	Мөнгөн дүн /сая.төг/
Сэргээн засах тусламж, үйлчилгээ	42 838	946.3	70 794	1 957.2
Гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ	7 538	188.5	41 545	1 286.5
Өдрийн эмчилгээ	7 259	217.6	52 871	2 013.4
Оношилгоо шинжилгээ	24 571	368.7	287 418	2729.0
<b>Нийт дүн</b>	<b>82 206</b>	<b>1 720.1</b>	<b>452 628</b>	<b>8 986.1</b>

*б/ Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын даатгалын сангаас төлөх төлбөр, тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн жагсаалт, өртгийн жин*

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд даатгалын сангаас төлбөр төлөхдөө 2000 он хүртэл ор хоногоор тооцдог байсан бол 2000-2007 он хүртэл 1 хэвтэн эмчлүүлэгчээр тооцож, 2007 оноос өртөг ойролцоо 22 оношийн бүлгээр, 2010 оноос өртөг ойролцоо 115 оношийн хамааралтай бүлэг болгон өргөжүүлсэн. Даатгуулагчид үзүүлэх тусламж, үйлчилгээний хувьсах зардлын даатгалын сангаас олгох хэмжээг эрүүл мэндийн байгууллагын шатлал харгалзахгүйгээр, тусламж, үйлчилгээний төрлөөр, төрийн өмчийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээнд олгох төлбөрийн хэмжээг ялгаатай тогтоож ирсэн.



Хэвтүүлж эмчлүүлэх төлбөрийн хэмжээ нь 2014 оны 01 дүгээр сарын 01-нээс мөрдөгдөж эхэлсэн бөгөөд төлбөрийн хэмжээ нь сүүлийн 6 жил өөрчлөгдөөгүй мөрдсөн.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулинд нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл "Төлбөрийн хэмжээ, жагсаалт, өртгийн жин, журам батлах тухай" тогтоолыг өөрчлөн 2020 оны 01 дүгээр сараас "Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн жагсаалт, журам"-ыг шинэчлэн, мөрдүүлж байна.

2019 онд Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь Эрүүл мэндийн яам, Сангийн яам, Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр эрүүл мэндийн байгууллагуудын өртгийн судалгааны оношийн хамааралтай нэгтгэсэн бүлгийн тооцоолол гаргасан бөгөөд үүнд үндэслэн 2020 оноос эрүүл мэндийн байгууллагуудын хэвтүүлэн эмчлүүлэх тусламж үйлчилгээний даатгалын сангаас төлөх төлбөрийн хэмжээ, өртгийн жинг шинэчлэн боловсруулсан.

Төрийн өмчийн болон хувийн хэвшлийн эмнэлгийг ижил хэмжээтэй буюу 400.000 төгрөг болгон төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагад олгох төлбөрийн хэмжээг 33.3 хувиар, хувийн өмчийн эрүүл мэндийн байгууллагад олгох төлбөрийн хэмжээг 128.6 хувь /2.3 дахин/-иар нэмэгдүүлэхээр шийдвэрлэв.

**Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын эрүүл мэндийн даатгалын сангаас төлөх төлбөрийн хэмжээ**

*Хүснэгт.7.*

Тусламж, үйлчилгээний төрөл	2019 оны 28 дугаар тогтоол			
	Төрийн өмчийн ЭМБ	Хувийн өмчийн ЭМБ	Төрийн өмчийн ЭМБ	Хувийн өмчийн ЭМБ
Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ	400 000	400 000	33.3	128.6
Өдрийн эмчилгээ, үйлчилгээ	180 000		33.3	
Амбулаторийн тусламж, үйлчилгээ	15 000		0.0	
Оношилгоо, шинжилгээ	55 000	55 000	0.0	
Уламжлалтын эмчилгээ	250 000	250 000	113.7	113.7
Сэргээн засах тусламж, үйлчилгээ	250 000	250 000	127.3	127.3
Сувиллын тусламж, үйлчилгээ	250 000	250 000	127.3	127.3
Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ	400 000	400 000	33.3	128.6
Хорт хавдрын тусламж, үйлчилгээ	Химийн өдрийн эмчилгээ	450 000	-	
	Туяаны өдрийн эмчилгээ	66 000	-	

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хэвтүүлэн эмчлэх оношийн хамааралтай бүлгийн жагсаалтыг 107 бүлэг байсныг 299 бүлэг болгон нэмэгдүүлж, оношийн хамааралтай бүлгийн жагсаалтад үйлдлийн ангиллаар нь өртгийн жинг ялгаатайгаар шинэчлэн тогтоож, өртгийн жинг хамгийн ихдээ 1,6 дахин өсгөсөн.

Уг тогтоол хэрэгжсэнээр хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн жагсаалтад өөрчлөлт орж, хүрээ өргөжих ба өртгийн жин нэмэгдэн, даатгуулагчид эрүүл мэндийн чанартай, хүртээмжтэй, цогц үйлчилгээг үзүүлэх боломжтой болно. Мөн хувийн хэвшлийн эмнэлгийн тусламж, үйлчилгээний төрөл, даатгалын сангаас хариуцах төлбөрийн хэмжээ нэмэгдэж даатгуулагчийн хувиасаа төлөх төлбөр буурч, эерэг үр дүн гарах болно.

*в/ Магадлан итгэмжлэгдсэн спортын клубд идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх үйлчилгээ*

2017 оны 07 дугаар сарын 06-ны өдөр Монгол Улсын Их хурал Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан “Даатгуулагчид үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ”-нд “Магадлан итгэмжлэгдсэн спортын клубд идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх үйлчилгээ” гэсэн заалт нэмж, 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр хуульчилсан юм.

Хуулийн энэхүү заалтын хэрэгжилтийг хангах хүрээнд эерэг болон сөрөг талуудыг харьцуулан, эдийн засаг, нийгмийн амьдралд үзүүлэх нөлөөлөл, үр дагаврыг урьдчилан тооцож, тухайн харилцааг зохицуулах үр дүнтэй зохицуулалт хийх шаардлага гарсан юм. Уг зорилгод нийцүүлэн “Магадлан итгэмжлэгдсэн спортын клубд идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх үйлчилгээнд эрүүл мэндийн даатгалын сангаас урамшуулал олгох журам” баталж, үйлчилгээний урамшуулалд эрүүл мэндийн даатгалын сангаас төлөх төлбөрийн хэмжээг тогтоож Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол гаргалаа.

Магадлан итгэмжлэгдсэн спортын клубд идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх үйлчилгээний урамшуулалд эрүүл мэндийн даатгалын сангаас төлөх төлбөрийн хэмжээг 60.000 /жаран мянга/ төгрөг байх юм. Уг журамд хуулийн хэрэгжилт хангах, даатгуулагчид өөрийн нас, хүйс, биеийн онцлог, сонирхлыг харгалзан даатгалын гэрээ бүхий спортын клубээс сонгож, тодорхой хөтөлбөр, зааврын дагуу өөрт тохирсон идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх үйлчилгээнд хамрагдах боломжтой. Тэдний эрүүл мэнд, бие бялдрын хөгжилд сайнаар нөлөөлж, амьдралын чанар сайжирч, улмаар урт хугацаандаа өвчний улмаас хэвтүүлэн эмчлүүлэх тохиолдлоор даатгалын санд ирэх ачаалал буурах талтай гэж үзлээ. Төлбөрийг даатгуулагч иргэнд шууд өгөх нь ашигтай гэж үзсэн бөгөөд ер нь спортын клубд жирийн иргэд хамрагдах нь бага, тодорхой бүлгийн цөөн иргэдэд энэ үйлчилгээ хийгдэж байгаа нь үр дүн багатай гэж иргэдийн зүгээс шүүмжлэлтэй хандаж байгааг цаашид анхаарч боловсронгуй болгох шаардлагатай байна.

*г/ Эмийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээ*

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл 2018 онд хөнгөлөлттэй Эмийн жагсаалтыг шинэчлэн 24 дүгээр тогтоолыг баталсан. Ингэснээр эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээнд өөрчлөлт орсон. Хөнгөлөлт үзүүлэх эм, түүний үнийн дээд хязгаар тогтоох асуудалд даатгуулагч иргэд, эмийн үйлчилгээ үзүүлэх байгууллагуудын зүгээс олон янзын байр суурь, санал хүсэлт гарах болсонд зохих

дүгнэлт хийж, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг томилж, Үндэсний зөвлөлийн хурлаар дахин хэлэлцүүлэв. Ажлын хэсгийн дүгнэлт болгосноор ахмад настны зонхилон хэрэглэдэг эмийн үнийг хөнгөллөө.

Энэ талаар Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт "Зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн үнэд эрх зүйн зохицуулалт бий болгох, эмийн аюулгүй байдлын мэдээллийн цахим санг үндэсний хэмжээнд байгуулж, эмийг цахим жороор олгож эхлэх" зорилтыг дэвшүүлж, 2019 онд ахмад настны зонхилон хэрэглэдэг эмийн үнийг 80 хүртэл хувиар хөнгөлөх чиглэл өгсөн юм. Энэ чиглэл зорилгод Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн шийдвэр нийцэж байгаа болно.

Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын эмийн аюулгүй байдлын цахим бүртгэл, хяналтыг нэвтрүүлэх ажлын хүрээнд Эрүүл мэндийн хөгжлийн төвийн цахим системд бүртгэгдсэн зайлшгүй шаардлагатай эмийн улсын бүртгэлтэй нийцүүлсэн, эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмүүдийг улсын бүртгэлийн дугаараар бүртгэлжүүлж байна. Одоогоор 605 эм хөнгөлөлттэй эмийн бүртгэлд бүртгэгдэж, 0-5 настай хүүхдийн 155 эм, нийтдээ 760 эм бүртгэлд ороод байна.

**Зайлшгүй шаардлагатай эмийн үнийн  
хөнгөлөлтийн зардал, 2017-2019 он, сая төгрөгөөр**

**Хүснэгт.8.**

Эрүүл мэндийн даатгалын сангийн зардал	2017 он		2018 он		2019 он	
	Гүйцэтгэл	Төсөв	Гүйцэтгэл	Төсөв	Гүйцэтгэл	Төсөв
Эмийн үнийн хөнгөлөлтийн зардал /сая. төгрөг/	26,814.9	30,881.6	25,914.0	33,987.3	33,401.6	
Эмийн үнийн хөнгөлөлт авсан даатгуулагчийн тоо /мянга. хүн/	1580.3		1435.5		1593.9	

2019 онд эмийн үнийн хөнгөлөлттэй үйлчилгээг 1.5 сая даатгуулагчид үзүүлж, даатгалын сангаас 33.4 тэрбум төгрөгийг зарцууллаа.

Төрөөс эм, эмнэлгийн хэрэгслийн үнийн талаар баримтлах тодорхой бодлогогүй байгаа нь эмийн үнэлгээний талаар маргаан үүсэх, эм, эмийн хэрэгсэл ханган нийлүүлэх болон эмийн жижиглэн худалдаа эрхэлдэг байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналт сулаас эмийн үнэ өсч, иргэдэд хүндрэлтэй байгаад дүгнэлт хийж, хууль эрх зүйн үндэслэлийг боловсронгуй болгох зайлшгүй шаардлагатай гэж Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл үзэж байна.

**2.1.3 Эрүүл мэндийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, орон тооны хангамж хүрэлцээ**

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөс Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан эрх хэмжээнийхээ хүрээнд Эрүүл мэндийн даатгалын байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг 2019 онд баталсан юм. Одоогоор Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар дарга, дэд даргатай, тамгын, бодлого хэрэгжилт, тусламж үйлчилгээний чанар, хяналт шалгалтын 4 газар, санхүү төлбөр, олон нийттэй

харилцах, мэдээлэл технологийн 3 хэлтэс, санхүү бүртгэл, төлбөрийн хяналт үнэлгээ, сургалт, сурталчилгаа, хэрэглэгчтэй харилцах 4 алба, 21 аймаг, нийслэлийн Багануур, Налайх дүүргүүдэд эрүүл мэндийн даатгалын тасагтайгаар ажиллаж байна. 15 аймагт тус бүр 2, 6 аймагт тус бүр 3, Багануур, Налайх дүүрэгт тус бүр 2 орон тоотой тасаг ажиллаж байгаа бөгөөд тасагт эрүүл мэндийн даатгалын тасгийн дарга буюу байцаагч эмч 1, эрүүл мэндийн даатгалын зардлын байцаагч 1-2 ажилтантай байна.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөс 2019 онд Эрүүл мэндийн даатгалын байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг судлан боловсруулах ажлын хэсэг байгуулан, эрүүл мэндийн даатгалын хуульд нийцүүлэн шинэ бүтэц, зохион байгуулалт, орон тооны хувилбар боловсруулсныг Үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэв. Уг бүтцийн дагуу орон тоо, зардлын тооцооллыг боловсруулан 2020 оны төсөвт тусгуулахаар Сангийн яаманд хүргүүлсэн.

Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь бие даасан ч хуульд заасан бүтэц бүрдээгүй, аймаг, дүүргийн ажил сул, хүн хүчний нөөц хомсдлоос шалтгаалан иргэдийг ЭМД-д хамруулах ажил бүрэн хийгдэхгүй, зарим ажил үйлчилгээ орхигдох зэрэг муу үр дагавар ажиглагдах болов.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын бие даасан тогтолцоог бүрдүүлэх, бодлогын болон үйл ажиллагааны зөв менежмент, маркетингийг хөгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авч байхаар Эрүүл мэндийн даатгалын байгууллагын ажлыг сайжруулах бодит шаардлага тавигдаж байна.

## **2.2 УИХ-ын НББСШУ-ны байнгын хорооны шийдвэр, үүрэг, чиглэлийн биелэлт**

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны тайланг хэлэлцээд Байнгын хороо Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрэмд өөрчлөлт оруулж тогтоол гарган, эрүүл мэндийн даатгалын бодлогын зарим асуудал, ЭМД-ын байгууллагын бүтэц, зохион байгуулалт, бие даасан байдлыг бэхжүүлэх, эрүүл мэндийн даатгалын хөрөнгийг банкинд байршуулах зэрэг арван асуудлаар тодорхой үүрэг, чиглэл протоколоор өгсөн юм.

Уг үүрэг, чиглэлийг хэрэгжүүлэх талаар авсан арга хэмжээ, хийгдэж буй ажил нь:

а/ Үндэсний зөвлөлийн санхүү, төсвийн бие даасан байдлыг хангаж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад санхүүгийн тайлангаа нэгтгүүлж, санхүүгийн үйлчилгээ авах боломжтой болгох талаар Эрүүл мэндийн даатгалын хуульд нэмэлт оруулах хуулийн төсөлд тусгалаа. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.9 дэх хэсэгт заасны дагуу эрүүл мэндийн даатгалын сангаас ЭМДҮЗ-ийн үйл ажиллагааг санхүүжүүлж байгаа ч хаана тайлагнах, төсвөө шууд захиран зарцуулах асуудал тодорхойгүйгээс ийм дутагдал, бэрхшээл гарч байгаа билээ.

ө/ Гэнэтийн давагдашгүй хүчин зүйл, эдийн засаг санхүүгийн хүндрэлийн нөлөөгөөр үүсэх эрүүл мэндийн даатгалын сангийн алдагдлыг нөхөх тогтвортой

байдлыг хангах, иргэдийн эрүүл мэндэд үүсч болох эрсдэлд зарцуулагдах зориулалттай эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сан байгуулж ажиллуулах хуулийн заалттай. Энэ талаар Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 20.2-т “Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн санг эрүүл мэндийн даатгалын сангийн тухайн жилийн орлогын 10 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээгээр байгуулна” гэж заасны дагуу 2019 онд Үндэсний зөвлөл даатгалын сангийн орлогын 8 хувиар тооцож, жил бүр эрсдэлийн санг бүрдүүлэхээр шийдвэрлэж, сангийн бүрдэлт, зарцуулалтын талаар журам баталсан. 2019 онд 31,6 тэрбум төгрөг, 2020 онд 41.7 тэрбум төгрөгийг төсөвт тусгуулахаар Сангийн яаманд хүргүүлсэн. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны төсвийн хүрээний мэдэгдлийн саналд сангийн орлогын 8 хувиар тооцож 48.6 тэрбум төгрөгөөр эрсдэлийн санг зарлагын бүрэлдэхүүнд тусган хүргүүлээд байна. Хэрэгжилт нь хангагдаагүй байгаа үндэс шалтгааныг судлан эрсдэлийн санг жил бүрийн төсөвт заавал тусгаж байх зарчмыг хуулиар тогтоох нь зүйтэй гэж үзлээ.

в/ Эрүүл мэндийн даатгалын байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг шинэчилж, аймаг, дүүрэгт эрүүл мэндийн даатгалын хэлтэс байгуулах, ажлын ачаалал, үүрэгтэй нь уялдуулж орон тоог авч үзэх тухай болон энэ талаар хууль эрх зүйн үндэслэлийг тодорхой болгохоор Байнгын хорооноос өгсөн үүргийн дагуу Эрүүл мэндийн даатгалын байгууллагын бүтэц, орон тооны дээд хязгаарыг шинэчлэх санал боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулж, Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн албаны тухай хуулийн хүрээнд өөрчлөлт оруулахтай холбоотой санал, танилцуулгыг боловсруулж, Засгийн газарт оруулаад байна. Үүнд 21 аймаг болон нийслэлийн эрүүл мэндийн даатгалын бүтцийн нэгжийг эрүүл мэндийн даатгалын хэлтэс болгон шинэчлэн зохион байгуулж, агентлагийн орон тооны дээд хязгаарыг 2020 оны батлагдсан төсвийн хүрээнд төв, орон нутагт нийт 199 орон тоотой ажиллуулах, эрүүл мэндийн даатгалын байгууллагын бүтцийг ЭМДҮЗ, Эрүүл мэндийн сайдаар шинэчлэн батлуулж байх асуудал тусгагдсан.

г/ Байнгын хорооноос эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомж, эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагаа болон эрүүл мэндийн даатгалд хамрагдахын давуу талыг олон нийтэд сурталчлах, даатгуулагчийг шаардлагатай мэдээллээр хангах ажлыг эрчимжүүлэх чиглэл өгсөн билээ.

Урьд онуудад эрүүл мэндийн даатгалын хамралтын байдлын тоог давхардсан тоогоор гаргадаг байсныг цахим системийг шинээр нэвтрүүлж, 2018 онд эрүүл мэндийн даатгалд даатгуулагчийн тоог анх удаа давхардалгүйгээр гаргасан. Үр дүн нь даатгалд хамрагдагсад 2017 оноос 160.0 орчим мянган хүнээр буурч хүн амын 88.9 хувь болсон бөгөөд 2019 онд зохиосон ажлын үр дүнд 2.9 сая иргэн хамрагдаж, хамралтын хувь 90.2 хувьд хүрлээ. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл хүн амын 10 хувь эрүүл мэндийн даатгалд хамрагдахгүй байгаа байдалд дүгнэлт хийж цаашид зохиох ажлаа эрчимжүүлэх арга хэмжээ авч байна.

д/ Төрөөс цахим системийг нэвтрүүлэх зорилтын хүрээнд эрүүл мэндийн даатгалын байгууллагад дэвшилтэт шинэ технологийг нэвтрүүлэх, иргэдийн оролцоог

хангах үндэсний цахим сүлжээнд төв, орон нутгийн Эрүүл мэндийн даатгалын байгууллагыг бүрэн хамруулж, цахим програмын хангамжийг шинэчлэн боловсруулах төсөл хөтөлбөрт хамрагдах, зөвлөгөө авах чиглэлээр Засгийн газар болон олон улсын төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж хамтран ажиллах чиглэл байнгын хороо өгсөн. Энэ дагуу эрүүл мэндийн даатгалын цахим системд орчин үеийн мэдээллийн технологийн боломж, нөөцийг ашиглан гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллагуудыг эрүүл мэндийн даатгалын системтэй цахимаар холбох, байгууллага иргэдийн харилцаанд нэвтэрч байгаа цахим системтэй уялдуулан мэдээллийг хянах тогтолцоо бүхий цахим системийг буй болгохоор ажиллаж байна. /Энэ талаар тайлангийн 2.5 дахь хэсэгт тодорхой дурдсан байгаа/

е/ Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын албаны ажилтны ангилал, зэрэглэлийг төрийн захиргааны албан тушаалын "ТЗ" ангилал, зэрэглэлд хамааруулах эсэх, эсхүл төрийн захиргааны албан хаагчтай дүйцүүлэн олгох эсэх тухай асуудлыг холбогдох хууль, эрх зүйн баримт бичигт өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх нь зүйтэй гэж үзээд Эрүүл мэндийн даатгалын хуульд нэмэлт өөрчлөлт оруулах төсөлд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын албаны ажилтныг "ТЗ"-ын албан хаагчийн статустай, "ТЗ"-ын албан хаагчдын ангилал, зэрэглэлээр цалин хангамжтай байх заалтыг оруулан УИХ-д өргөн барихаар бэлтгэв.

ё/ Эрүүл мэндийн даатгалын сангийн арилжааны банкуудад байршуулж буй хадгаламжийн хүүгийн зөрүүтэй байдалд дүгнэлт хийж, хүүгийн хэлбэлзлэлийг бууруулах арга хэмжээ авах чиглэлээр Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл тодорхой арга хэмжээ авлаа. "Эрүүл мэндийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг зарцуулах, банкинд хадгалуулах, Засгийн газрын бонд, Монголбанкны үнэт цаас худалдан авах журам"-ыг шинэчлэн баталсан. 2019 онд шинээр байршуулсан жилийн хугацаатай мөнгөн хадгаламжийг 12.0-14.8 хувийн хүүтэйгээр гэрээ хийсэн ба жигнэсэн дундаж хүү 12.66 хувь болсон Монголбанкнаас гаргадаг улсын байгууллагын хадгаламжийн хүүгийн жигнэсэн дундаж хүү /оны эцсийн байдлаар/ 11.71 байгаагаас даруй 0.95 хувийн пунктаар илүү байна. Эрүүл мэндийн даатгалын хадгаламжийн хүүгийн зөрүүтэй байдал арилсан гэж үзэж байна.

ж/ Жил бүрийн эхэнд Үндэсний зөвлөлийн хуралдаанаар банкинд байршуулах хадгаламжийн дээд хэмжээ, хүүгийн түвшинг банк тус бүрээр батлах, тухайн банкинд байршуулах хадгаламжийн хэмжээ, хүүгийн хувийг тогтоохдоо банкны зохистой харьцааг хангаж байгаа эсэх, активын хэмжээгээр эрсдэл даах чадвар, ашиг, алдагдлын хэмжээг нь тооцдог байхын тулд ЭМДҮЗ энэ оны эхэнд 448.0 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгийг хадгаламж хэлбэрээр байршуулахаар тогтоож, ингэхдээ банкинд байршуулах хадгаламжийн дээд хэмжээ, хүүгийн түвшин, Монголбанкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангах, активын хэмжээгээр эрсдэл даах чадвар, ашиг, алдагдлын хэмжээг нь банк тус бүрээр авч үзэж шийдвэр гаргасан юм. Хадгаламжийн хүүг тогтоохдоо үзүүлэлт болгон авсан хүүгийн дунджаас гадна банкуудын санал болгосон өндөр хүүг харгалзан тогтоох арга хэмжээ авсан. 2019 онд хадгаламжийн хүүгийн доод хэмжээ 11.8 хувь байлаа.

Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооноос эрүүл мэндийн даатгалын талаар гаргасан шийдвэр, өгсөн үүрэг, чиглэлийн биелэлтийг хавсаргав.

### 2.3 Монгол Улсын Засгийн газрын шийдвэр, мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт

Засгийн газрын 2017 оны 112 дугаар тогтоолд элэгний хорт хавдар, хатуурлын нас баралтыг эрс бууруулах, элэгний С вирусийн голомтыг 2020 он гэхэд устгаж, халдварын тархалтыг таслан зогсоох “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн II шатны зорилтыг хэрэгжүүлэхээр заасан. Энэ зорилтыг хангахын тулд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл 2019 оны 10 дугаар сард тогтоол гаргаж, Эрүүл мэндийн даатгалын сангаас төлөх төлбөрийн хэмжээг шинэчлэн баталсан.

Үүнд: Хепатитийн В, С вирусийн анхдагч илрүүлэг шинжилгээний зардлыг 3500 төгрөгөөр, хепатитийн В, С вирусийн анхдагч илрүүлэг шинжилгээний хариу сул эерэг, эргэлзээтэй гарсан тохиолдолд илрүүлгийн нэмэлт шинжилгээний зардлыг 5.0-10.0 мянган төгрөгөөр, хепатитийн В, С вирусийн идэвхжил тодорхойлох шинжилгээний дээд хязгаарыг хагас автоматаар тодорхойлоход 80.0 мянган төгрөг, бүрэн автоматаар тодорхойлоход 120.0 мянган төгрөг, хепатитийн D вирусийн илрүүлэг шинжилгээний зардлыг 15.0 мянган төгрөг, идэвхжил тодорхойлох шинжилгээний төлбөрийн дээд хязгаарыг 120.0 мянган төгрөгөөр тус тус тооцон төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагаас даатгуулагчид үзүүлсэн оношилгоо, шинжилгээний зардлын төлбөрийг даатгалын сангаас бүрэн хариуцаж байна.

Мөн даатгуулагчдын тавьсан хүсэлтийг харгалзан элэгний D вирусийн илрүүлэг, идэвхжил тодорхойлох шинжилгээний зардлын төлбөрийг нь гүйцэтгэлээр тооцон эрүүл мэндийн даатгалын сангийн 2019-2020 оны батлагдсан төсвийн хүрээнд хийхээр төлөвлөж байна.

#### Эрүүл мэндийн даатгалын сангаас “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрт зарцуулсан зардал, 2017-2019 он

Хүснэгт.9.

“Элэг бүтэн Монгол” хөтөлбөрт зарцуулсан зардал	2017 он	2018 он		2019 он	
	Гүйцэтгэл /сая төг/	Хүний тоо, мян	Гүйцэтгэл /сая төг/	Хүний тоо, мян	Гүйцэтгэл /сая төг/
Элэгний В, С вирусийн эсрэг эмийн үнийн хөнгөлөлт	11,300.0	65.1	11,865.3	28.5	7,146.9
Элэгний В, С вирусийг илрүүлэх, баталгаажуулах шинжилгээний зардал	-	427.2	1,547.1	1,005.4	686.5
Элэгний В, С вирусийн идэвхжил тодорхойлох шинжилгээний зардал	6,643.70	56.0	6,449.5	98.7	7,244.6
<b>Нийт</b>	<b>17,943.7</b>	<b>548.3</b>	<b>19,861.9</b>	<b>1,132.6</b>	<b>15,077.3</b>

“Элэг бүтэн Монгол” хөтөлбөрт 2018 онд 19.8 тэрбум төгрөг, 2019 онд 15.1 тэрбум төгрөг тус тус зарцуулж, 2019 онд В, С вирусийн илрүүлэг шинжилгээнд 1.0 сая

хүн, баталгаажуулах шинжилгээнд 4.7 мянган хүн, В, С вирусийн идэвхжил тодорхойлох шинжилгээнд 98.7 мянган даатгуулагч хамрагдсан. Эмийн үнийн хөнгөлөлтийг 28.5 мянган даатгуулагчид үзүүлж, 123.6 мянган ширхэг В, С вирусийн эм олгосон байна.



## ГУРАВ. ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл нь эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хяналт тавих дээд байгууллага бөгөөд Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагаанд даатгагч, даатгуулагч, ажил олгогч, Засгийн газрын тэгш оролцоог хангах, төрийн бодлого, эрүүл мэндийн даатгалын байгууллагын алсын хараа, хэтийн зорилгыг хууль эрх зүйн хүрээнд тодорхойлон хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, сангийн орлого, зарлагын төсвийн төсөл, төсөөлөл боловсруулах, санхүүгийн тайланг хэлэлцэн үнэлэлт, дүгнэлт өгөх, тусламж үйлчилгээний нэр төрлийг тогтоох, эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгох, эрүүл мэндийн даатгалтай холбогдолтой хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих зэрэг хуулиар тогтоосон чиг үүрэгтэй.


### 3.1 Бүтэц, зохион байгуулалт

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл 2018 оноос УИХ-ын НББСШУ-ны байнгын хорооноос баталсан бүтэц, орон тооны дагуу ажлын албатай, 12 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна. Ажлын алба нь Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хангах, Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг хэвийн явуулахад туслах чиг үүрэгтэй байгууллага юм.

Ажлын албаны бүтэц, зохион байгуулалт, орон тоонд сүүлийн 2 жилд өөрчлөлт ороогүй болно.

#### ЭМДҮЗ-ийн бүтэц

График.1.



### 3.2 2019 оны үйл ажиллагаа

Тайлант хугацаанд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл 12 удаагийн хуралдаан зохион байгуулж, нийт 41 асуудал хэлэлцэж, 30 тогтоол гаргасан. Захиргааны ерөнхий хуулийн дагуу нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний 5 актыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хянуулан, улсын бүртгэлд бүртгүүллээ.

Үүнд сангийн мөнгөн хөрөнгийн чөлөөт үлдэгдлийг банкинд хадгалуулах тухай, эрүүл мэндийн даатгалын сангаас олгох тусламж үйлчилгээний төлбөр, урамшуулал олгох тухай, эрүүл мэндийн байгууллагыг сонгон шалгаруулах зэрэг 5 журам болон эмийн үнэ, өртгийн жин, төлбөрийн хэмжээ, үнэ тарифын холбогдолтой 4 жагсаалт багтаж байна.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл 2018 оны үйл ажиллагааны тайланг УИХ-ын НББСШУ-ны байнгын хороогоор хэлэлцүүлсэн бөгөөд Байнгын хороо, Монгол Улсын Засгийн газарт тодорхой үүрэг, чиглэл бүхий шийдвэр гаргаж өгсөн юм. Уг шийдвэрийн биелэлтийг тусгайлан гаргаж, Эрүүл мэндийн даатгалын сангийн чөлөөт мөнгөн хөрөнгийн мэдээг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраар гаргуулан Байнгын хороонд улирал тутам хүргүүлж байна.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл өөрийн дотоод үйл ажиллагаатай холбоотой 6 тогтоол, Ажлын албаны дарга 29 тушаал гаргасан байна. Үндэсний зөвлөл ажлаа жилээр төлөвлөж, 2019 оны төлөвлөгөөнд 41 асуудал тусгасны биелэлт 92 хувьтай байна. Зөвлөлийн гишүүд, ажлын албаны ажилтнуудтай хамтран Сүхбаатар, Хэнтий, Хөвсгөл зэрэг 9 аймгийн эрүүл мэндийн даатгалын тасаг, тэдгээрийн үйл ажиллагаатай танилцаж, ЭМДҮЗ-өөс гаргасан тогтоол, шийдвэрийн биелэлтийг шалган, мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө.

Мөн өртгийн жин, тарифын судалгаа, эмийн үнэ болон Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, ЭМД-ын байгууллагын бүтэц, зохион байгуулалт, Капитал банкны талаар Үндэсний зөвлөлийн гишүүд, ажлын албаны ажилтнуудын оролцоотой ажлын хэсгүүд байгуулан, хяналт шалгалт, судалгаа хийж, дүнгээ Үндэсний зөвлөлд танилцуулсан.

Ажлын алба Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар, Баримт бичгийн улсын стандарт дагуу 141 албан бичиг, 8 өргөдөл хүлээн авч, 86 албан бичигт бүртгэл хяналтын карт хөтөлж, шийдвэрлэлтэд хяналт тавьж, 157 албан бичиг холбогдох байгууллага, иргэдэд явуулсан байна. Архивын нөхөн бүрдүүлэлт 26 нэгжээр нэмэгдэж, архивд 57 хадгаламжийн нэгж хадгалагдаж байна.

2019 онд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн батлагдсан төсөв 313,3 сая төгрөгөөс 232,4 сая төгрөгийг зарцуулан, Төсвийн тухай хуулийг баримтлан ажиллаж, санхүүгийн өр төлбөр, авлагагүй үүсгээгүй бөгөөд Зөвлөлийн санхүүгийн үйл ажиллагаанд Үндэсний аудитын газраас аудит хийж, зөрчилгүй үнэлэлт, дүгнэлт өгсөн.

## ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, САНАЛ

1. Тайлант хугацаанд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагаа цаг үеийн тавигдаж буй зайлшгүй шаардлага болон Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нийцүүлэн даатгалын харилцааг боловсронгуй болгохтой холбогдсон журам, зааврыг шинэчлэх, УИХ-ын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооноос гаргасан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж даатгалын сангийн үйл ажиллагааг сайжруулахад илүүтэй анхаарсан гэж үзэхээр байна. Мөн өмнө гаргасан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн шийдвэрийн биелэлтийг хангах арга хэмжээ авч ажилласан. Ийнхүү авсан арга хэмжээ, зохиосон ажлын үр дүнд 2019 онд даатгалын орлогын төлөвлөгөө бүрэн хангагдаж, зарлага санхүүжилт цаг тухайдаа хийгдсэн байна. Тайлант онд 469.4 тэрбум төгрөгийн орлого эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 115.2 хувиар давуулан биелүүлсэн.

2. Эрүүл мэндийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө өсөн нэмэгдэж, баталсан төсвийг бүрэн санхүүжүүлэн, даатгуулагч иргэдийн эрсдэлийг хуваалцах хөрөнгийн боломжтой нөөц хангалттай бүрдсэн гэж үзэж байна. Эрүүл мэндийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл өссөн дүнгээр 557.5 тэрбум төгрөг, Капитал банкны 136.1 тэрбум төгрөгийг нэмж тооцвол 693.6 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна. Энэ нь өмнөх оноос 118.6 тэрбум төгрөгөөр өссөн дүн юм.

3. Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээ үзүүлдэг байгууллагын тоо сүүлийн 2 жилд нэмэгдлээ. 2019 онд нийт 2122 эрүүл мэндийн байгууллагатай гэрээ байгуулж, давхардсан тоогоор 8.6 сая даатгуулагчид эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүллээ. Үүнд эрүүл мэндийн даатгалын сангаас 346.1 тэрбум төгрөгийг зарцуулсан. Гэлээ ч эрүүл мэндээ даатгуулсан иргэдэд чанартай ажил үйлчилгээ худалдан авах нөхцөлийг бүрдүүлэх талаар цаашдаа ихээхэн анхаарах шаардлага гарч байна. Иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд зарцуулахаар төсөвлөсөн мөнгөн хөрөнгө тухайн жилдээ бүрэн зарцуулагдахгүй үлдэгдэл гарч байна. 2019 онд эрүүл мэндийн даатгалд зарцуулахаар төсөвлөсөн хөрөнгөөс 56.7 тэрбум төгрөг хэмнэгдлээ.

4. Өнгөрч буй онд эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх 4 төрлийн тусламж үйлчилгээ шинээр нэмэгдэж, төлбөрийн хэмжээ 2.2-2.8 дахин өслөө. Энэ нь анхан шатлалын тусламж үйлчилгээг иргэдэд ойртуулсан арга хэмжээ болсон юм. Цаашдаа өрх, сум, тосгоны эрүүл мэндийн байгууллагуудаас даатгуулагчдад үзүүлэх тусламж, үйлчилгээнд эрүүл мэндийн даатгалын сангаас хуваарилах төсөв хөрөнгийг нэмэгдүүлэх бодлогыг Үндэсний зөвлөл баримталж байна.

5. Хэвтүүлэн эмчлүүлэх тусламж, үйлчилгээний даатгалын сангаас төлөх төлбөрийн хэмжээ 6 жилийн турш өөрчлөлтгүй байсныг төр, хувийн өмчийн эмнэлгийг ижил хэмжээтэй буюу 400.000 төгрөг болгон төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагад олгох төлбөрийн хэмжээг 33.3 хувиар, хувийн өмчийн эрүүл мэндийн байгууллагад олгох төлбөрийн хэмжээг 128.6 хувь /2.3 дахин/-аар нэмэгдүүлсэн нь ач

холбогдолтой гэж үзэж болохоор ч үүний нөгөө талд иргэдийг өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэхэд эрүүл мэндийн даатгалын хөрөнгийг илүүтэй зарах шаардлага бодлогын түвшинд тавигдаж байна.

6. Эрүүл мэндийн даатгалын байгууллагын хүний нөөц, боловсон хүчний хангамж хомсдолтой, гадаад, дотоодод сургаж бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх хэрэгцээ, шаардлага гарч байна. Эрүүл мэндийн даатгалын байгууллага өнөөгийн бүтцээр аймаг, дүүрэгт үйл ажиллагаа явуулахад хүчин мөхөсдөж байна. Үүнээс шалтгаалан иргэдийг ЭМД-д хамруулах ажил бүрэн хийгддэггүй, эрүүл мэндийн даатгалын ач холбогдлыг сурталчлах, даатгуулагчидтай ажиллах ажиллагаа орхигдох сөрөг үр дагавартай байна. Нэг сая гурван зуун мянган хүн ажиллаж амьдарч буй нийслэлд эрүүл мэндийн даатгалын зүгээс даатгуулагчдад туслалцаа үзүүлэх, иргэдтэй биечлэн уулзах, санал хүсэлтийг сонсох ажил орхигдож, малчид, оюутан, суралцагчдыг эрүүл мэндийн даатгалд хамруулах даатгалын орлогын эх үүсвэрээ нэмэгдүүлэх боломжийг алдаж байгаад дүгнэлт хийж, цаашид авах арга хэмжээг боловсруулж байна.

7. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл иргэдээс эрүүл мэндийн даатгалыг төлөх шимтгэлийн хувь хэмжээг нэмэгдүүлэх чиглэлийг баримтлахгүй байгаа ч шимтгэл төлөгч гадаадын иргэн, харъяалалгүй иргэд нь өндөр үнэтэй тусламж үйлчилгээг Монгол улсын иргэдтэй адил хэмжээний бага үнээр авдаг нь даатгалын санд тодорхой хэмжээний алдагдалтай гэж үзэж, энэ талаар Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүдээс гаргасан саналыг харгалзан Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 6.1.4-д заасан гадаадын иргэн, харъяалалгүй хүний эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нэмэгдүүлэх асуудлыг судалж байна.

8. Эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгийг арвижуулах, эргэлтийг түргэтгэх замаар эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх боломж гүйцэд ашиглагдахгүй байна. Энэ талаар эрүүл мэндийн даатгалын байгууллагаас хийх ажлыг оновчтой тодорхой болгох, менежментийг зохих түвшинд сайжруулах шаардлагатай. Капитал банкныг татан буулгах талаар мэдээлэл хомс, Монголбанк гэнэтийн шийдвэр гаргасан, Капитал банкинд хадгалагдаж байсан хөрөнгийг нэн даруй татан авах талаар ЭМДЕГ Үндэсний зөвлөлөөс өгсөн чиглэлийг хэрэгжүүлж, хуулийн байгууллагад хандаагүй цаг алдсанд дүгнэлт хийж ажиллаж байна. Үүний зэрэгцээ Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөс төсөвт суулгаж өгсөөр байхад Сангийн яам, Засгийн газраас төлөх 0-18 насны хүүхдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 420.0 мянган төгрөгөөр бодохыг өмнөх оны хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр /320.0 мянган төгрөгөөр/ бодож 2020 оны эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг 37.9 тэрбум төгрөгөөр бууруулсан. Энэ мэтээр Эрүүл мэндийн даатгалын санг ил, далд хэлбэрээр хохироох байдал гарч байна. 2020 оны төсвийн тодотголоор дээрх дутуу тооцогдсон хөрөнгийг Засгийн газраас Эрүүл мэндийн даатгалын санд нөхөн оруулах нь зохистой гэж үзлээ.

9. Эрүүл мэндийн даатгалын хуулиар даатгалын эрсдэлийн санг байгуулах үүрэгтэй ч энэ заалт хэрэгжихгүй явж ирлээ. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл хуульд заасны дагуу эрсдэлийн санг байгуулж, зарцуулах журмыг батлаж, 2019, 2020 оны төсөвт зохих хөрөнгийг тусган Сангийн яаманд хүргүүлснийг Сангийн яам Засгийн газрын хурлаар оруулахгүй дур мэдэн хассан байна. Ийм шалтгааны

улмаас эрүүл мэндээ даатгуулагч иргэд хохирч, даатгалын санд санхүүгийн эрсдэл гарахад нөхөх боломжгүй байдалтай байна.

Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сангийн хөрөнгийг жил бүрийн төсөвт тусгуулах талаар анхаарал тавихыг УИХ-ын Төсвийн болон Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд хүсэлт болгож байна.

10. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн зарим заалт бүрэн хэрэгжихгүй байгаад дүгнэлт хийж, эрх зүйн үндэсийг тодорхой болгох нарийвчлан тогтоох талаар НББСШУ-ны байнгын хорооноос Засгийн газарт өгсөн үүргийг хэрэгжүүлэхийн тулд Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн зарим зүйл заалтад нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулан УИХ-ын гишүүдээр өргөн бариулахаар бэлтгэлээ. Хуулийн төслийг хэлэлцэн батлуулж өгөхийг Байнгын хороонд хүсэлт болгож байна.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулгыг хавсаргав.

--oOo--

## Тайланд холбогдох диаграм, хүснэгт

## Хүснэгт.1. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2018-2019 оны төсвийн гүйцэтгэл /сая.төгрөг/

Эрүүл мэндийн даатгалын сан			2018 он		2019 он	
			Төсөв	Гүйцэтгэл	Төсөв	Гүйцэтгэл
А. ОРЛОГО			376 011.9	422 340.3	407 667.3	469 419.8
1	Үүнээс:	Аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогчийн төлөх шимтгэл	97 695.4	112 082.1	100 615.0	123 447.5
2		Даатгуулагчийн төлөх шимтгэл	119 572.2	137 180.9	122 486.6	150 369.6
3		Төсөвт байгууллагын төлөх шимтгэл	36 192.0	41 523.7	44 502.3	54 500.8
4		Бусад даатгуулагчийн төлөх шимтгэл	15 501.2	16 490.0	83 885.0	83 804.1
5		Төр даатгалыг нь хариуцах иргэдийн шимтгэл	67 723.8	67 468.4	16 845.7	14 759.0
6		Бусад орлого	39 327.3	47 595.1	39 332.7	42 538.8
Б. ЗАРЛАГА			341 330.6	311 731.4	407 667.3	350 956.4
1	Үүнээс:	Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудад олгосон зардал	214 507.9	213 248.2	244 554.0	236 812.2
2		Хувийн хэвшлийн эмнэлэгт олгосон зардал	42 005.8	35 081.7	48 823.7	37 325.9
3		Рашаан, сувилалд олгосон зардал	12 680.8	10 133.5	13 080.8	10 597.9
4		Өрхийн эрүүл мэндийн төвөөс үзүүлэх зарим сэргээн засах үйлчилгээ, өдрийн эмчилгээ, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ, оношлогоо, шинжилгээний зардал	5 200.0	1 720.2	15 891.5	8 986.1
5		Зайлшгүй шаардлагатай эмийн үнийн хөнгөлөлтийн зардал	30 881.6	25 914.0	34 987.3	33 402.3
6		Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээний зардал	5 014.5	2 211.5	10 123.0	3 925.3
7		"Элэг бүтэн Монгол" хөтөлбөрт зарцуулсан зардал	26 748.6	19 861.9	31 711.0	15 077.3
8	Үүнээс:	Элэгний В, С вирусийг илрүүлэх, баталгаажуулах шинжилгээ	3 685.6	1 547.1	3 689.0	686.5
9		Элэгний В, С вирусийн идэвхжил тодорхойлох шинжилгээ	6 450.0	6 449.5	11 465.0	7 244.6
10		Элэгний В, С вирусийн эсрэг эмийн үнийн хөнгөлөлт	16 613.0	11 865.3	16 557.0	7 146.9
11	Үйл ажиллагааны зардал	4 017.9	3 379.1	5 422.4	4 569.1	
12	Үүнээс	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны урамшуулал	33.6	5.5	33.6	0.5
13		Илүү төлсөн шимтгэлийн буцаан олголт	240.0	175.8	240.0	259.0

## Хүснэгт 2. Даатгалын гэрээ бүхий байгууллагуудын 2019 оны гэрээний үнэлгээ

		Үзүүлэлт	Нийслэл	Аймаг, дүүрэг	Бүгд
Байгуул ага	Гэрээ байгуулсан Эрүүл мэндийн байгууллагын тоо		819	1303	2122
	Үүнээс: Гэрээ дүгнүүлсэн		732	1269	2001
	Хамрагдалтын хувь		93	97	96
Үнэлгээ /оноогоор/	81-100 оноогоор үнэлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын тоо		688	1159	1847
	71-80 оноогоор үнэлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын тоо		32	103	135
	60-70 оноогоор үнэлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын тоо		10	7	17
	59-өөс доош оноогоор дүгнэгдсэн эрүүл мэндийн байгууллагын тоо		2	0	2
Үнэлгээний дундаж оноо			94	91	89


**График .1. Эрүүл мэндийн даатгалын хамралтын түвшин /2016-2019 он/**



**Гарфик .2. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого /тэрбум төгрөг/**




**График.3. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын бүтэц 2019 он**




- Ажил олгогч, даатгуулагчийн шимтгэлийн орлого - 328.4 тэрбум.төг
- Төр даатгалыг нь хариуцах иргэдийн шимтгэлийн орлого-83.8 тэрбум.төг
- Шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг даатгуулагчийн шимтгэлийн орлого-14.8 тэрбум.төг
- Бусад орлого -42.7 тэрбум.төг


**График.4. Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагын бүтэц**



**График.5. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрүүл мэндийн даатгалын сангаас төлөх төлбөрийн хэмжээ /2010-2019 он/**




**График .6. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээний хамрагдалт /2018-2019 он**






## График 7. “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт /тусламж, үйлчилгээний төрлөөр, аймгаар, өссөн дүнгээр/



Зураг .8. Даатгалын гэрээтэй байгууллага болон тусламж, үйлчилгээ авсан даатгуулагчийн өсөлт



Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн  
2019 оны үйл ажиллагааны тайлангийн хавсралт 2.

**НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ  
УХААНЫ БАЙНГЫН ХОРООНЫ ШИЙДВЭР,  
ӨГСӨН ҮҮРЭГ, ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТ**

№	Байнгын хорооны хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг, чиглэл	Биелэлт
1	<p>Үндэсний зөвлөл Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас санхүүжилтаа авч, санхүүгийн тайлангаа мөн газарт нэгтгүүлж байгаа нь хэрэгжүүлэгч агентлагаасаа санхүү, төсвийн хувьд хараат байх нөхцөлийг бий болгож байгаа тул Үндэсний зөвлөлийн санхүү, төсвийн бие даасан байдлыг хангаж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад санхүүгийн тайлангаа нэгтгүүлэх, санхүүгийн үйлчилгээ авах боломжтой болгох</p>	<p>Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.9 дэх хэсэгт заасны дагуу эрүүл мэндийн даатгалын сангаас ЭМДҮЗ-ийн үйл ажиллагааг санхүүжүүлж байна.</p> <p>УИХ-аар Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийг нэгдсэн байдлаар баталдаг бөгөөд ЭМДҮЗ-н ажлын албанаас саналыг авч, жилийн төсвийн төслөө боловсруулан харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлдэг болно.</p> <p>Мөн Төсвийн тухай хуулийн 8.9.1-д "Төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлдэг болно.</p>
2	<p>Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сан нь гэнэтийн давагдашгүй хүчин зүйл, эдийн засаг, санхүүгийн хүндрэлийн нөлөөгөөр үүсэх эрүүл мэндийн даатгалын сангийн алдагдлыг нөхөх, тогтвортой байдлыг хангах, иргэдийн эрүүл мэндэд үүсч болох эрсдэлд зарцуулагдах зориулалттай зориулсан сан тул Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөс ирүүлсэн саналыг үндэслэн жил бүр төсөвт суулгаж, батлуулах;</p>	<p>Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн санг эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 20.2-т "Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн санг эрүүл мэндийн даатгалын сангийн тухайн жилийн орлогын 10 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээгээр байгуулна" гэж заасны дагуу 2019 сангийн орлогын 8%-иар тооцож 31,6 тэрбум төгрөг, 2020 онд мөн орлогын 8%-иар тооцон 41.7 тэрбум төгрөгийг төсөвт тусгуулахаар Сангийн яаманд хүргүүлсэн боловч тусгагдаагүй болно. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны төсвийн хүрээний мэдэгдлийн саналд сангийн орлогын 8 хувиар тооцож 48.6 тэрбум төгрөгөөр сангийн зарлагын бүрэлдэхүүнд тусган хүргүүлээд байна. УИХ төсөв батлах үед хуулийн энэ шаардлагын хэрэгжилт хангаж буй эсэхэд хяналт тавих боломжтой юм. Эрсдэлийн санг жил бүрийн төсөвт заавал тусгах тухай хуулийн төсөлд тусгалаа.</p>
3	<p>Эрүүл мэндийн даатгалын байгууллагын бүтэц, зохион</p>	<p>Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг</p>

	<p>байгуулалтыг шинэчилж, аймаг, дүүрэгт эрүүл мэндийн даатгалын хэлтэс байгуулах, ажлын ачаалал, үүрэгтэй нь уялдуулж орон тоог зохих төвшинд нэмэх, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиар тогтоосон хязгаарт багтааж дээрх зардлыг төсөвт тусгах нь зүйтэй гэж үзлээ.</p> <p>Дээрх асуудалтай холбогдуулан Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай санал, төслөө боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;</p>	<p>боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр ажиллаж байна .</p> <p>ЭМДЕГ-н даргын 2020 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн а/12 дугаар тушаалаар Эрүүл мэндийн даатгалын байгууллагын бүтэц, орон тооны дээд хязгаарыг шинэчлэх санал боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.</p> <p>Ажлын хэсгээс Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн албаны тухай хуулийн хүрээнд агентлагийн орон тооны дээд хязгаарыг тогтоосон 2017 оны 344 дүгээр тогтоолд өөрчлөлт оруулахтай холбоотой санал, танилцуулгыг боловсруулж, 2020 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн а-1/220 дугаар албан бичгээр Эрүүл мэндийн сайдад уламжилсан</p> <p>Үүнд: агентлагийн орон тооны дээд хязгаарыг шинэчлэн батлуулах тухай төслийн танилцуулга, нөлөөллийн шинжилгээ, Засгийн газрын тогтоолын төсөл, хуралдааны тэмдэглэл.</p> <p>Дээрх тогтоолын төсөлд 21 аймаг болон нийслэлд ажиллах эрүүл мэндийн даатгалын бүтцийн нэгжийг эрүүл мэндийн даатгалын хэлтэс болгон шинэчлэн зохион байгуулан, агентлагийн орон тооны дээд хязгаарыг 2020 оны батлагдсан төсвийн хүрээнд 199 орон тоогоор батлуулах, эрүүл мэндийн даатгалын байгууллагын зохион байгуулалтын бүтцийг ЭМДҮЗ, Эрүүл мэндийн сайдаар шинэчлэн батлуулах, 2021 оны төсөвт үйл ажиллагааны зардлыг үе шаттайгаар тусгуулах заалтыг тусгасан.</p>
4	<p>Эрүүл мэндийн даатгалын байгууллагаас эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомж, эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагаа болон эрүүл мэндийн даатгалд хамрагдахын давуу талыг олон нийтэд сурталчлах, даатгуулагчийг шаардлагатай мэдээллээр хангах ажлыг эрчимжүүлэх;</p>	<p>Урьд онуудад Эрүүл мэндийн даатгалын хамралтын тоог давхардсан тоогоор гаргадаг байсан.</p> <p>Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь бие дааснаар Эрүүл мэндийн даатгалын цахим системийг шинээр нэвтрүүлж, эрүүл мэндийн даатгалд даатгуулагчийн тоог анх удаа давхардаагүй тоогоор гаргасан бөгөөд 2018 онд нийт хүн амын 88.9 хувь нь даатгалд хамрагдсан нь 2017 оныхоос 160.0 орчим мянган хүнээр буюу 6.7 пунктээр буурсан үзүүлэлттэй гарсан юм.</p> <p><b>Давхардсан тоогоор</b> авч үзвэл 2018 онд 3067,8 мянган даатгуулагч эрүүл мэндийн даатгалд хамрагдаж, хамралтын төвшин 98.0 хувьтай буюу урьд оныхоос 2.4 пунктээр нэмэгдсэн.</p> <p>2019 онд эрүүл мэндийн даатгалд <b>давхардаагүй тоогоор</b> 2920.8 мянган даатгуулагч хамрагдаж, хамралтын хувь 90.2 хувьтай гарсан байна.</p>
5	<p>Төрөөс цахим системийг нэвтрүүлэх зорилтын хүрээнд эрүүл мэндийн даатгалын байгууллагад дэвшилтэт шинэ технологийг нэвтрүүлэх, иргэдийн оролцоог хангах,</p>	<p>Эрүүл мэндийн даатгалын цахим системд орчин үеийн мэдээллийн технологийн боломж, нөөцийг ашиглан гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллагуудыг эрүүл мэндийн даатгалын системтэй цахимаар холбох, байгууллага иргэдийн харилцаанд нэвтэрсэн байгаа цахим баримтын</p>

	<p>даатгалтай холбоотой мэдээлэл, өгөгдлийг даатгуулагчдад нээлттэй болгох үүднээс үндэсний цахим сүлжээнд төв, орон нутгийн Эрүүл мэндийн даатгалын байгууллагыг бүрэн хамруулж, цахим программын хангамжийг шинэчлэн боловсруулах, төсөл хөтөлбөрт хамрагдах, зөвлөгөө авах чиглэлээр Засгийн газар болон олон улсын төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар хамтран ажиллах;</p>	<p>системтэй уялдуулан–мэдээллийг хянах тогтолцоо бүхий цахим системийг хөгжүүлэхээр зорьж байна. Эрүүл мэндийн даатгалын салбарын хэмжээнд 2019 оны 10 дугаар сараас эхлэн даатгалын гэрээтэй хувийн хэвшлийн эмнэлэг, сувилал, сэргээн засах төвүүдэд ЭМД-ын төлбөрийн Е баримтын системийг бүрэн нэвтрүүлж, даатгуулагчдад НӨАТУС-ийн баримтыг тусламж, үйлчилгээ авах бүрт олгож, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний мэдээлэлд цахимаар хяналт тавих хуулиар хүлээсэн эрхийг эдлүүлэх боломжийг бүрдүүллээ. Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь даатгуулагч иргэдэд зориулсан “Ухаалаг утасны аппликейшн”-ийг зах зээлд нэвтрүүлэхээр зорьж, 12 дугаар сараас туршилтын журмаар хэрэгжүүлж байна. “Ухаалаг утасны аппликейшн”-ийг бүрэн нэвтрүүлснээр даатгуулагчийн эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлт болон эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын болон даатгалын гэрээтэй эрүүл мэндийн байгууллага, эмийн сангийн мэдээллийг шаардлагатай үедээ цаг алдалгүй авах боломжтой болох юм.</p>
6	<p>Нийгмийн даатгалын болон Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын албаны ажилтны ангилал, зэрэглэлийг төрийн захиргааны албан тушаалын ТЗ ангилал, зэрэглэлд хамааруулах эсэх, эсхүл төрийн захиргааны албан хаагчтай дүйцүүлэн олгох эсэх тухай асуудлыг холбогдох хууль, эрх зүйн баримт бичигт өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх</p>	<p>Эрүүл мэндийн даатгалын хуульд нэмэлт өөрчлөлт оруулах төсөлд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын албаны ажилтныг ТЗ-ын албан хаагчийн статустай, мөн ТЗ-ын ангилал, зэрэглэлээр цалин хангамжтай байх заалтыг оруулан УИХ-д өргөн барихаар бэлтгээд байна.</p>
7	<p>Эрүүл мэндийн даатгалын сангийн арилжааны банкуудад байршуулж буй хадгаламжийн хүүгийн зөрүүтэй байдалд дүгнэлт хийж, хүүгийн хэлбэлзлэлийг бууруулах;</p>	<p>Хадгаламжийн хүүгийн зөрүүтэй байдлыг арилгах, мөнгөн хөрөнгийн хадгаламжийн эрсдэлийг бууруулахаар Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2019 оны “Эрүүл мэндийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг зарцуулах, банканд хадгалуулах, Засгийн газрын бонд, Монгол банкны үнэт цаас худалдан авах журам”-ын 11 тоот тогтоолын хоёрдугаар хавсралтаар шинэчлэн баталсан. Мөн 2019 онд шинээр байршуулсан жилийн хугацаатай мөнгөн хадгаламжийг 12.0-14.8 хувийн хүүтэйгээр гэрээ хийсэн ба жигнэсэн дундаж хүү 12.66 хувь байгаа нь Монголбанкнаас гаргадаг улсын байгууллагын хадгаламжийн хүүгийн жигнэсэн дундаж хүү 2019 оны 12 дугаар сарын байдлаар 11.71 байгаагаас даруй 0.95 хувийн хүүгээр илүү</p>

		байна. Даатгалын хадгаламжийн хүүгийн зөрүүтэй байдал арилсан гэж үзэж байна.
8	Жил бүрийн эхэнд Үндэсний зөвлөлийн хуралдаанаар банкинд байршуулах хадгаламжийн дээд хэмжээ, хүүгийн төвшинг банк тус бүрээр батлах, тухайн банканд байршуулах хадгаламжийн хэмжээ, хүүгийн хувийг тогтоохдоо банкны зохистой харьцааг хангаж байгаа эсэх, активын хэмжээгээр эрсдэл даах чадвар, ашиг, алдагдлын хэмжээг нь тооцдог байх;	2020 оны ЭМДҮЗ-ийн 03 дугаарын тогтоолоор энэ жил мөнгөн хадгаламж хэлбэрээр байрших 448.0 тэрбум төгрөгийг батлав. Ингэхдээ банкинд байршуулах хадгаламжийн дээд хэмжээ, хүүгийн төвшин, Монголбанкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэх, активын хэмжээгээр эрсдэл даах чадвар, ашиг, алдагдлын хэмжээг нь банк тус бүрээр авч үзэж шийдвэр гаргасан.
9	Хадгаламжийн хүүг тогтоохдоо үзүүлэлт болгон авсан хүүгийн дунджаас гадна банкуудын санал болгосон өндөр хүүг харгалзан тогтоох;	Хадгаламжийн хүүг тогтоохдоо үзүүлэлт болгон авсан хүүгийн аль өндөр хэмжээнээс буулгахгүй байх гэснээр мөнгөн хадгаламжийн хүүгийн доод хэмжээг 11.8 хувьд барив. Хадгаламж байршуулахдаа банкны системд нөлөө бүхий банкнуудаас мөнгөн хадгаламж байршуулах саналыг авч нэгтгэн ЭМДҮЗ-ийн хурлаар хэлэлцэв.
10	Эрүүл мэндийн даатгалын сангаас Капитал банкинд байршуулсан хадгаламжийн хөрөнгийг холбогдох яам, агентлагийн төсвийн эрх захирагч нар шийдвэртэй арга хэмжээ авч ажиллахыг чиглэл болгох.	2019 онд эрх бүхий байгууллагын шийдвэрээр Капитал банкныг татан буулгаж, эрх хүлээн авагч томилсонтой холбогдуулан эрүүл мэндийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийг эргэн төлүүлэх, нэхэмжэлийн шаардлагыг хангуулах зорилгоор ЭМДҮЗ-ийн 2019 оны 13 дугаар тогтоол, ЭМДЕГ-ын даргын 2019 оны А/121 дүгээр тушаалаар ажлын хэсгийг байгуулсан. Тус ажлын хэсгүүд нь татан буугдсан банкны эрх хүлээн авагчидтай уулзалт зохион байгуулах, ЭМД-ын сангийн хохирлыг нэн яаралтай барагдуулахдаа иргэдийн хадгаламж гэдэг талаас хандах, тайлбар, танилцуулга, шаардлагыг холбогдох байгууллагад хүргүүлэн, нэхэмжлэлийн хөрөнгийн хэмжээг 136,1 тэрбум төгрөгөөр баталгаажуулсан. Капитал банкинд байршуулсан эрүүл мэндийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө нь Банкны тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1.8-д заасан төлбөрийн дараалалд бүртгэгдсэн тул Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэдийн эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг эдлүүлэх, тэдний эрүүл мэндийн улмаас учирч болзошгүй санхүүгийн эрсдлийг хуваалцах, тусламж, үйлчилгээг худалдан авах зорилгоор урьдчилан бүрдүүлсэн эрүүл мэндийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийг Банкны тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1.5-т заасан дараалалд оруулах, нэн даруй төлүүлэх талаар шаардлагатай арга хэмжээг авч холбогдох хуульд заасны дагуу Иргэний хэргийн анхан шатны шүүхэд хандах хүсэлт гарган, Сангийн яам,

		<p>Монголбанктай хамтран ажиллаж байна. Капитал банк дахь банкны эрх хүлээн авагчид төлбөр барагдуулах дараалал урагшлуулах тухай нэхэмжлэл гаргасан, Нийслэлийн захиргааны хэргийн шүүх хурал хойшлогдсонтой холбоотой эцсийн үр дүн гараагүй байгаа.</p>
--	--	--

### ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

## **ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

### **Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага**

Эрүүл мэндийн даатгалын /ЭМД-ын/ тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2015 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хурлаар баталсан бөгөөд 2016, 2017 онд 6 удаагийн нэмэлт, өөрчлөлтүүд хийгдсэн байна. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т “эрүүл мэндийн даатгалын байгууллага” гэж эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгийг бүрдүүлж, даатгуулагчийн өмнөөс эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээдийг;” ойлгохоор заасан.

Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 344 дүгээр тогтоолын дагуу ЭМД-ын байгууллага нь 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн статустайгаар Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

ЭМД-ын тухай хуульд ЭМД-ын байгууллагын бие даасан үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн хэдий ч хуульд заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэхэд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл /ЭМДҮЗ/-ийн зарим эрх, үүрэг хязгаарлагдмал, хуульд найруулга, редакцийн өөрчлөлт оруулаагүйгээс зарим төрийн байгууллагатай чиг үүргийн давхардал, зөрчил үүсч байна. Хууль тодорхой, хоёрдмол утгагүй, нийтэд ойлгомжтой байх үүднээс хуульд зарим нэмэлт, өөрчлөлтийг зайлшгүй оруулах шаардлагатай гэж үзлээ.

### **1.2. Практик шаардлага**

1.2.1. ЭМД-ын тухай хууль хэрэгжсэнээр аялал жуулчлалын зорилгоор тус улсад ирсэн гадаадын иргэн, харъяалгүй хүн /БНХАУ, Турк, Энэтхэг ...гэх мэт/ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тухайн жилийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төлөөд даатгалын сангаас өндөр өртөгтэй тусламж, үйлчилгээ болон эмийн үнийн хөнгөлөлтийн зардлыг /элэгний С вирусийн эсрэг эм/ авах эрсдэл үүссэн тул 2016 оны нэмэлт өөрчлөлтөөр сангийн хөрөнгийг эрсдлээс хамгаалах зохицуулалтыг бий болгосон.

2016 оноос хойш ЭМД-ын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3-т заасан гадаадын иргэн, харьяалалгүй хүн /аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан/ Нийгмийн даатгалын тухай хуулийн дагуу нийгмийн даатгалын шимтгэлийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс 1 сар төлөөд эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг хариуцах бүх тусламж, үйлчилгээг авах боломжтой байгаа тул бусад улс орны жишгийн дагуу өндөр өртөгтэй тусламж, үйлчилгээ болон эмийн үнийн хөнгөлөлтийн зардлыг дээрх даатгуулагчид хязгаарлах нь зүйтэй байна.

1.2.2. ЭМД-ын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 16.5.1-т жороор олгох эмийг ЭМД-ын сангаас хариуцахаар заасан бөгөөд тарилгын шингэн болон дуслын эмийг зөвхөн эмнэлгийн нөхцөлд, эмчийн хяналтанд хэрэглэх заалттай тул иргэн, даатгуулагч эмнэлгийн бус нөхцөлд хэрэглэснээс гарах сөрөг үр дагаврыг арилгах шаардлагатай.

1.2.3. “ЭМД-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 2017 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн өөрчлөлтөөр ЭМД-ын сангаас зардлын төлбөрийг

хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцын 9.1.12-т “магадлан итгэмжлэгдсэн спортын клубд идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх үйлчилгээ”-г шинээр нэмсэнтэй холбоотой хуулийн 9.4 дэх хэсэгт “...магадлан итгэмжлэгдсэн спортын клубд идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх үйлчилгээнд урамшуулал олгох журмыг ...Үндэсний зөвлөл батална.” гэж хуульчилсан. Хуулийн 9.1-т заасан тусламж, үйлчилгээний багцыг ЭМД-д даатгуулсан бүхий л даатгуулагч авах эрхтэй тул санд ирэх ачааллыг бууруулах үүднээс 9.1.12 дахь заалтыг хасаж, хуулийн 9.4-т заасан “.....спортын клубд идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх үйлчилгээнд урамшуулал олгох журам”-аар зохицуулах нь зүйтэй гэж үзлээ.

### **Хоёр. Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.21-т “ЭМД-ын бие даасан байгууллагыг бүрдүүлж, даатгуулагч төвтэй, орчин үеийн менежмент бүхий стратегийн идэвхтэй худалдан авагч болгон хөгжүүлэх” зорилтын хүрээнд ЭМДЕГ нь 2018 оноос эхлэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг гэрээний дагуу олгох чиг үүргийг хэрэгжүүлж байгаа бөгөөд дараах зөрчилтэй заалтуудыг өөрчлөх шаардлагатай гэж үзэж байна.

2.1.ЭМД-ын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д “ЭМД-ын даатгалын байгууллагын тогтолцоо нь ...эрүүл мэндийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллага, аймаг дүүргийн нийгмийн даатгалын хэлтсээс бүрдэнэ” гэж заасан ч өнөөгийн байдлаар ЭМДЕГ нь аймаг, дүүрэгт бүтцийн нэгжгүй, орон нутагт Нийгмийн даатгалын хэлтэс төр хариуцахаас бусад эрүүл мэндийн даатгалын сангийн шимтгэлийн орлого цуглуулах, төвлөрүүлэх үйл ажиллагааг, Эрүүл мэндийн даатгалын тасаг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авах чиг үүргийг тус тус хэрэгжүүлж байгаа тул эрүүл мэндийн даатгалын байгууллагын орон нутгийн салбарын эрх зүйн байдлыг тодорхой болгох үүднээс “нийгмийн даатгалын хэлтэс” гэсний “нийгмийн” гэдгийг “эрүүл мэндийн” гэж өөрчлөх.

2.2.Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.16-д “Иргэн хувийн эмнэлгээр үйлчлүүлэхэд ЭМД-аас хөнгөлөх зардлын хэмжээг нэмэгдүүлж, иргэнд учрах төлбөрийн дарамтыг бууруулах” зорилт дэвшүүлсэн. ЭМДҮЗ-ийн “Төлбөрийн хэмжээ, жагсаалт, өртгийн жин, журам батлах тухай” 2019 оны 28 дугаар тогтоолоор хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад даатгалын сангаас олгох тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээг нэмэгдүүлсэнтэй холбоотой эрүүл мэндийн байгууллагын үүрэгт “энэ хуулийн 14.9.9, 14.9.10-т зааснаас нэмэгдүүлж төлбөр авахгүй байх” гэж нэмэх.

2.3.Эмнэлгийн нөхцөлд, эмчийн хяналтанд хэрэглэх заалттай тарилгын шингэн болон дуслын эмэнд даатгалын сангаас хөнгөлөлт үзүүлэх, эмнэлгийн бус нөхцөлд хэрэглэх сөрөг үр дагавраас сэргийлэх үүднээс хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийг “Даатгуулагч энэ хуулийн 9.1.7-д заасан жороор эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлт олгох эмийн жагсаалтад орсон зайлшгүй шаардлагатай эмийг худалдан авах тохиолдолд үнийн хөнгөлөлт үзүүлнэ.” гэж өөрчлөн найруулав.

2.4.УИХ-ын НББСШУБХ нь ЭМДҮЗ-ийн 2019 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцээд ЭМД-ын байгууллагын бүтэц, орон тоо, зохион байгуулалтыг шинэчлэх, аймаг, дүүрэгт эрүүл мэндийн даатгалын хэлтэс байгуулах, орон тоог ажлын ачаалалтай нь уялдуулан нэмэгдүүлэх, эрсдэлийн сангийн зардлыг төсөвт тусган батлуулах, ЭМДҮЗ-ийн ажлын албаны ажилтан, тэдний цалин, хөлсийг төрийн захиргааны адилтгах, албан хаагчтай дүйцүүлэн олгох асуудлыг судалж,



шийдвэрлэх, шаардлагатай тохиолдолд ЭМД-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай санал, төслөө боловсруулан УИХ-д өргөн мэдүүлэх талаар Засгийн газарт үүрэг өгсний дагуу хуульд зохих өөрчлөлт оруулж байна.

Энэхүү ЭМД-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь дараах өөрчлөлтөөс бүрдэнэ. Үүнд:

1. Нэмэлт оруулах
2. Зарим хэсэг, заалтыг өөрчлөн найруулах
3. Зарим хэсэг, заалтыг хасах
4. Хууль хүчин төгөлдөр болох асуудал

#### **Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль эрх зүйн үр дагавар**

ЭМД-ын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т “энэ хуулийн 20.1.6-20.1.9-д заасан зардал Энэ хуулийн 20.1.6-20.1.9-д заасан зардал нь Үндэсний зөвлөл, ЭМД-ын байгууллага болон нийгмийн даатгалын байгууллагын энэ хуулийн 19.3-т заасан үйл ажиллагааны зардал/ ЭМД-ын сангийн тухайн жилийн орлогын 5 хувиас илүүгүй байна.” гэж заасан нь жилдээ 25,3 тэрбум төгрөгийг зарцуулах боломжтой юм. ЭМД-ын сангийн 2020 оны төсөв 506.5 тэрбум төгрөг бөгөөд ЭМД-ын байгууллагын үйл ажиллагааны зардлын төсөв хэмнэлттэй, нийт 5.4 тэрбум төгрөг батлагдсан. Энэ нь сангийн орлогын 1.1 хувийг эзэлж байгаа нь ЭМД-ын сан болон улсын төсвөөс ямар нэгэн нэмэлт хөрөнгө шаардагдахгүй.

ЭМД-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагавар гарахгүй. Харин урт болон богино хугацаанд дараахь эерэг үр дүн гарах болно. Үүнд:

1. ЭМД-ын байгууллагын бүтэц, зохион байгуулалт оновчтой болж, бие даасан байдал хангагдаж, хүн хүчний болоод санхүүгийн нөөц нэмэгдэнэ.
2. ЭМД-ын байгууллагын хүний нөөц нэмэгдэхээс гадна ЭМД-ын үр шимийг хүртэгчдийн тоо өсөж, үйлчилгээний хүртээмж нэмэгдэнэ.
3. Иргэд ЭМД-ын ач холбогдлыг илүү ойлгож, даатгалд хамрагдах сонирхол болон даатгалын сангийн орлого ч нэмэгдэнэ.
4. ЭМД-ын сангийн менежмент сайжирч, стратегийн худалдан авагч байгууллага болоход ойртоно.

**Дөрөв. Хуулийн төсөл нь бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар**

ЭМД-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол улсын Үндсэн хууль, бусад хууль, эрх зүйн шинэтгэлийн бодлогод бүрэн нийцэж байгаа болно.

ЭМД-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар бусад хууль тогтоомжид өөрчлөлт орохгүй.

ЭМД-ын тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг энэхүү хууль батлагдсанаар дагаж мөрдөнө.

## ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

“Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай” (ИЭМДТ) хууль 1993 онд батлагдсанаас хойш нийт 9 удаагийн нэмэлт, өөрчлөлтийг оруулж, 2006, 2015 онд шинэчлэн найруулсан ба “Эрүүл мэндийн даатгалын (ЭМД-ын) тухай хуулийн шинэчилсэн найруулга”-ыг 2015 онд баталснаас хойш нийт 6 удаагийн нэмэлт, өөрчлөлтийг оруулжээ. Эдгээр өөрчлөлт нь ЭМД-ын тогтолцоог боловсронгуй болгож, бие даасан байдлыг хангахад бүхэлдээ чиглэгдэж иржээ.

ЭМД-ын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсанаар нийгмийн амьдралд тулгамдсан олон асуудлыг эрүүл мэндийн даатгалын шинэчлэлийн хүрээнд шийдвэрлэх боломжийг бүрдүүлсэн. Тухайлбал, ЭМД-ын шимтгэлийн хувь хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулан тогтоох, ЭМД-ын сангаас хариуцах тусламж, үйлчилгээний багц, нэр төрлийг нэмэгдүүлэн анх удаа өндөр өртөгтэй тусламж үйлчилгээ, хорт хавдрын химийн болон туяаны өдрийн эмчилгээ, анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх 4 төрлийн тусламж, үйлчилгээний зардлыг даатгалын сан хариуцах, улсын төсвөөс санхүүждэг зарим тусламж, үйлчилгээг гэрээний үндсэн дээр худалдан авах, ЭМД-ын байгууллагыг бие даасан хэлбэрээр ажиллуулах зэрэг стратегийн ач холбогдолтой олон чухал асуудлыг шийдвэрлэсэн.

Монгол Улсад ЭМД-ын шинэ тогтолцоог нэвтрүүлж, амьдралд хэрэгжүүлснээс хойшхи 25 жилийн хугацаанд 1995-2019 онд даатгалын санд 2.5 их наяд төгрөгийн орлого төвлөрүүлж, 1.9 их наяд төгрөгийн даатгуулагчийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг худалдан авч, давхардсан тоогоор 65.0 сая гаруй иргэнд эрүүл мэндийн даатгалын үйлчилгээ үзүүлсэн байна.

Монгол Улсад дэлхийн улс орны эрүүл мэндийн даатгалын нийтлэг чиг хандлага, өөрийн орны өвөрмөц онцлог нөхцөлд нийцүүлэн эрүүл мэндийн даатгалын шинэ тогтолцоог нэвтрүүлж, амьдралд хэрэгжүүлэх эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг нийгмийн даатгалын байгууллага 23 жилийн хугацаанд эрхлэн гүйцэтгэсэн байна.

ЭМД-д 2019 онд давхардаагүй тоогоор 2.9 сая даатгуулагч буюу нийт даатгуулагчийн 90,2 орчим хувийг хамруулж, санд 407.6 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 469.6 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 115.2 хувиар буюу 62.0 тэрбум төгрөгөөр давуулан биелүүлсэн нь 2015 онтой харьцуулахад сангийн орлого 189,4 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Хуульд зааснаар Нийгмийн даатгалын байгууллага албан журмын эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлогыг гэрээний үндсэн дээр ЭМД-ын санд төвлөрүүлж, Эрүүл мэндийн даатгалын байгууллага эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төрөөс хариуцан төлөх иргэдийн шимтгэлийн төлөлт, ногдуулалтыг бүхэлд нь хариуцан гүйцэтгэж байна.

ЭМД-ын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, нэр төрөл нэмэгдсэнтэй холбоотой 2019 онд нийт 2122 эрүүл мэндийн байгууллагатай эрүүл мэндийн даатгалын байгууллага гэрээ байгуулан давхардсан тоогоор 9,0 сая даатгуулагчдад 353.9 тэрбум төгрөгийн тусламж, үйлчилгээг үзүүлж, эрүүл мэндийн даатгалын сан болон улсын төсвөөс худалдан авалт хийсэн нь 2015 онтой харьцуулахад даатгалын гэрээтэй эрүүл мэндийн байгууллагын тоо 214 хувиар, тусламж, үйлчилгээ авагчдын тоо 177.9 хувиар, сангийн зарлага 180.3 хувиар нэмэгдсэн. Энэ нь 2017 оноос төр төлбөрийг нь хариуцах гемодиализийн тусламж, үйлчилгээ, “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөр, 2018 оноос өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх 4 төрлийн тусламж, үйлчилгээ, 2019 оноос “Эрүүл шүд-Эрүүл хүүхэд” хөтөлбөрт хамрагдсан 2-12 насны хүүхдийн амны хөндийн тусламж, үйлчилгээний зардлыг худалдан

авах үйл ажиллагааг ЭМД-ын байгууллага гүйцэтгэх болсонтой холбоотой. Ингэснээр ЭМД-ын байгууллагын ажилтнуудын ажлын ачаалал болон үйлчлэх цар хүрээ огцом нэмэгдэж байна.

ЭМД-ын сангийн удирдлага, менежментийн үндсэн чиг үүрэг нь шимтгэл цуглуулж, хөрөнгө төвлөрүүлэхээс гадна төвлөрүүлсэн хөрөнгөөр даатгуулагчдад чанартай, хүртээмжтэй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, бүх талаар туслахад чиглэгдэх ёстой ч тэдэнтэй ажиллах хүн хүчний нөөц дутагдалтай байна.

Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 344 дүгээр тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг–“Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар”-ыг 2018 оноос Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд зохион байгуулж, тус газрын орон тооны дээд хязгаарыг 55-аар баталсан.

Агентлаг шинээр байгуулагдахад энэ чиглэлээр ажиллаж байсан 62 албан хаагч ЭМД-ын байгууллагад шилжин ирсэн. Орон нутагт 21 аймаг, Нийслэлийн Налайх, Багануур дүүрэгт 45 хүн ажиллаж байна.

ЭМДҮЗ-ийн 2017 оны 03 дугаар тогтоолоор баталсан анхны бүтцээр ЭМДЕГ нь хуулиар олгогдсон чиг үүргээ хэрэгжүүлэхийн тулд 3 газар, 4 хэлтэстэй, төв, орон нутгийн хэмжээнд 139 орон тоогоор үйл ажиллагаа явуулж байна.

Харин орон нутаг дахь ЭМД-ын тасаг нь тасгийн дарга буюу байцаагч эмч-1, ЭМД-ын зардлын байцаагч-1, нийт 2-3 хүнтэй ажилладаг бөгөөд ЭМД-ын хууль, тогтоомжийг орон нутагт хэрэгжүүлэх чиглэлээр сангийн орлогыг бүрдүүлэх, хамралтыг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн байгууллагатай даатгалын гэрээ байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих, гэрээ дүгнэх, сангийн орлого, зарлагын төсвийн төсөл, төсөөллийг боловсруулах, эрүүл мэндийн байгууллагуудын даатгуулагчид үзүүлсэн тусламж, үйлчилгээний зардлын төлбөр, нэхэмжлэл, жагсаалтыг хүлээн авч, хянаж шалгах, санхүүжилтийг олгох нөхцлийг бүрдүүлэх, тусламж, үйлчилгээний чанарт хяналт тавих, иргэд, даатгуулагчдад салбарын хууль тогтоомжийг сурталчлах, иргэд-даатгуулагчид болон харилцагч байгууллагын санал хүсэлт, өргөдөл гомдлыг шийдвэрлэх зэрэг бүхий л ажлыг хийж гүйцэтгэх үүрэгтэй ажиллаж байна. Гэвч хүн хүчний нөөцийн хомсдлоос шалтгаалан хуульд заасан дээрх чиг үүргээ бүрэн биелүүлэх, иргэдийг ЭМД-хамруулах ажил бүрэн хийгдэхгүй, орхигдох үр дагавар гарч байна.

ЭМД-ын байгууллага нь хүний нөөцийн, санхүүгийн хувьд хангалттай чадавх бүрдээгүй байгаа тул даатгуулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эрүүл мэндийн даатгалын тогтолцоог төлөвшүүлэх, ЭМД-ын сангийн менежмент болон бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох шаардлагатайг харгалзан ЭМД-ын тухай хуульд зарим нэмэлт, өөрчлөлтийг орууллаа.

Хуулийн 3 зүйлд нэмэлт, 13 зүйлд өөрчлөн найруулж, хуулиас 1 заалтыг хасаж төслийг бэлтгэв. Хуульд шинээр бүлэг нэмэгдээгүй болно.

Хуулийн төсөл батлагдсанаар ЭМД-ын сан болон улсын төсвөөс нэмэлт хөрөнгө шаардагдахгүй бөгөөд ЭМД-ын байгууллагын үйл ажиллагааны зардал нь хуульд зааснаар илүү хэмнэлттэй явагдах боломжтой юм.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны .. дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй.

**1/9 дүгээр зүйлийн 9.7 дахь хэсэг:**

"9.7.Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3-т заасан даатгуулагч нь эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг 6 сараас доошгүй хугацаанд тасралтгүй төлсөн тохиолдолд энэ хуулийн 9.1.6, 9.1.7, 9.1.8-д заасан тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг олгоно."

**1/14 дүгээр зүйлийн 14.8.8 дахь заалт:**

"14.8.8.эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар санал, дүгнэлт гаргах."

**1/20 дугаар зүйлийн 20.6 дахь хэсэг:**

"20.6. Энэ хуулийн 20.1.9-д заасан зардлыг эрүүл мэндийн даатгалын сангийн жил бүрийн төсөвт тусгаж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад санхүүгийн тайланг нэгтгүүлнэ."

**2 дугаар зүйл.** Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн "Эрүүл мэндийн тухай хууль" гэсний дараа "Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай" гэж, 13 дугаар зүйлийн 13.1.9 дэх заалтын "хасч тооцох" гэсний дараа "энэ хуулийн 14 дүгээр зүйлийн 14.9.9, 14.9.10-т заасныг нэмэгдүүлж төлбөр, хураамж авахгүй байх" гэж, 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсгийн "хэмжээгээр байгуулна." гэсний дараа "эрүүл мэндийн даатгалын сангийн жил бүрийн төсөвт тусган батлуулна." гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 14<sup>1</sup>.5 дахь хэсгийг доор дурдсанаар тус тус өөрчлөн найруулсугай:

"9.3.Даатгуулагч энэ хуулийн 9.1.7-д заасан жороор эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлт олгох эмийн жагсаалтад орсон зайлшгүй шаардлагатай эмийг худалдан авах тохиолдолд үнийн хөнгөлөлт үзүүлнэ."

14<sup>1</sup>.5.Үндэсний зөвлөл ажлын албатай байх бөгөөд ажлын албаны ажилтнууд нь төрийн захиргааны жинхэнэ албан хаагч байна. Ажлын албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтны цалин хөлсийг төрийн захиргааны албан тушаалын "ТЗ" ангилал зэрэглэлтэй дүйцүүлэн тогтооно.

**4 дүгээр зүйл.** Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.8 дахь заалтын “хүүхдээ хоёр /ихэр бол гурав/ нас хүртэл” гэснийг “хүүхдээ гурван нас хүртэл” гэж, 7 дугаар зүйлийн 7.1.8 дахь заалтын “6.1.4” гэснийг “6.1.3” гэж, 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийн, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн, 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгийн “нийгмийн” гэснийг “эрүүл мэндийн” гэж, 14 дүгээр зүйлийн 14.8.1 дэх заалтын “дүрмийг” гэснийг “дүрэм, орон тоо” гэж, 14<sup>1</sup>.5 дахь хэсгийн “байна” гэснийг “байх бөгөөд” гэж, 15<sup>1</sup> дүгээр зүйлийн 15<sup>1</sup>.3 дэх хэсгийн “Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан” гэснийг “Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.1-д заасан” гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.** Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8 дахь заалтаас “6.1.4” гэснийг, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “9.1.12” гэснийг, 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн “нийгмийн даатгалын,” гэснийг, 14 дүгээр зүйлийн 14.9.8 дахь заалтын “болон нийгмийн даатгалын” гэснийг, 14.9.9, 14.9.10, 14.9.11 дэх заалтын “нийгмийн даатгалын болон” гэснийг, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “Нийгмийн болон” гэснийг тус тус хассугай.

**6 дугаар зүйл.** Энэ хуулийг 202.. оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**ГАРЫН ҮСЭГ**